

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-30
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл	31-122
	1.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2018.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	31-51
	2.“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	52-72
	3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	72-92
	4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/	92-94
	5.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/	94
	6.“Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”, “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд	94-104
	7.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	104-106
	8.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	106-110
	9.Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	110-114
	10.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	114-120
	11.Ажлын хэсэг байгуулах тухай /Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай/	120-122

Хураангуй тэмдэглэл

Гурав.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Д.Мөнхтуяа, Б.Ундрах, Д.Эрдэнэбалсүрэн, Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Амардэлгэр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач О.Мөнхсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Хонгорзул, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, С.Бямбацогт, Н.Алтанхуяг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач О.Мөнхсайхан нар хариулж, тайлбар хийв.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн зарим заалтыг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Нэг.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх саналын томъёолол.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал.

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.2 дахь хэсэг нэмэх:

“4.2.Шүүх нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудлыг болон Засгийн газрын улс төрийн шийдвэрийг хянан хэлэлцэхгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Х.Нямбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 9
Бүгд: 13
30.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.8.8 дахь заалт нэмэх:

“25.8.8.улс төрийн намын бүртгэл хөтлөх;” гэсэн саналыг дэмжье гэсэн хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал.

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ш.Адъяаа, Н.Алтанхуяг, Ц.Мөнх-Оргил, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “гэж” гэсний дараа “эрүү, иргэн, захиргаа зэрэг” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “хэргийн” гэсний дараа “зэрэг” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “дөрвөн” гэснийг “хоёр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсгийн “сонгосон” гэсний дараах “шүүгч” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 1

Бүгд: 13

92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 20.13 дахь хэсэг нэмэх:

“20.13.Энэ хуулийн 20.2.3-т заасан тайланг Нийт шүүгчийн чуулганаар сонсохдоо хэлэлцүүлэг явуулахгүй бөгөөд дүгнэлт, шийдвэр гаргахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.9.Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар гаргасан албан ёсны тайлбар, Улсын дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой гэж үзсэн шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 0

Бүгд: 12

100 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 24.5 дахь хэсэг нэмэх:

“24.5.Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй хэрэг, маргааны талаар сургалтын хөтөлбөр, арга зүйд тусгахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 0

Бүгд: 12

100 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “тухай саналыг Ерөнхийлөгчид, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай албан бичгийг Улсын Их Хуралд холбогдох баримт бичгийн хамт хүргүүлнэ.” гэснийг “саналыг, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулснаар томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 7 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 36.2, 36.3 дахь хэсэг болгож, 36.2.6 дахь заалтыг хасах:

“36.2.Улсын Их Хурал Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 104 дүгээр зүйлд заасан журмын дагуу танилцана.

36.3.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 36.2-т заасны дагуу Улсын Их Хурал танилцсан нэр дэвшигчийг долоо хоногийн дотор Улсын дээд шүүхийн шүүгчээр томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн гарчгийн “Шүүгчийн” гэсний өмнө “Шүүх,” гэж нэмж, 46.5 дахь хэсгийн “хүндэтгэлийн” гэснийг “хүндэтгэл, энэ хуулийн 15.6-д заасны дагуу томилолтоор ажиллах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 0
Бүгд: 12
100 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 46.7 дахь хэсгийн “журам, шалгуур үзүүлэлтийг” гэснийг “шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журмыг” гэж өөрчлөх:

“46.2.Шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн албанд ажилласан хугацааны, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 0
Бүгд: 12
100 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 10 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 47 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 1
Бүгд: 13
92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалтын “өв залгамжлагчид” гэснийг “гэр бүлд” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 48.9 дэх хэсэг нэмэх:

“48.9.Шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гарахад түүний авч байсан сарын дундаж цалингийн хэмжээгээр 36 сарын хугацаагаар тооцож нэг удаагийн тэтгэмж олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.8 дахь хэсгийн “тухайн шүүгчийг оролцуулан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 58 дугаар зүйлийн 58.1.6 дахь заалтын “51.1.23” гэснийг 58.1.7 дахь заалтад шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 77 дугаар зүйлийн 77.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“77.10.Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүний албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлс, нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсгийн “дийлэнх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 1
Бүгд: 13
92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 96 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 96.21 дэх хэсэг нэмэх:

“96.21.Сахилгын хорооны төсвийг боловсруулж батлахад энэ хуулийн 46.8-д заасан журмыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 1
Бүгд: 13
92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 98 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 98.4, 98.5 дахь хэсэг нэмэх:

“98.4.Сахилгын хорооны гишүүн энэ хуулийн 44.2-т заасан этгээдтэй уулзсан, харилцсан бөгөөд уг этгээд өөрөө, эсхүл бусдаар дамжуулан аливаа хэлбэрээр нөлөөлсөн, нөлөөлөхөөр оролдсон, үүрэг, чиглэл өгсөн бол энэ талаарх мэдээллийг агуулсан тэмдэглэл үйлдэн Сахилгын хороонд битүүмжлэн ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх үүрэгтэй.

98.5.Сахилгын хороо энэ хуулийн 98.4-т заасны дагуу битүүмжлэн ирүүлсэн тэмдэглэлийг хадгалах бөгөөд Сахилгын хорооны гишүүний өөрийнх нь, эсхүл эрх бүхий байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдэд гарган өгнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 84 дүгээр зүйлийн 84.9 дэх хэсгийн, 99 дүгээр зүйлийн 99.6 дахь хэсгийн “106.1.1-106.1.4-т заасан эрхийг эдэлнэ.” гэснийг “103.1.1, 103.1.2-т заасан эрх эдэлж, 103.2-т заасан үүргийг биелүүлнэ.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 100 дугаар зүйлийн гарчгийн “гишүүнийг” гэсний дараа “чөлөөлөх,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 100.1 дэх хэсэг нэмэх:

“100.1 .Сахилгын хорооны дарга, гишүүнийг дараах үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

100.1.1.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

100.1.2.өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, эрүүл мэндийн байдал, бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

100.1.3.өөрөө хүсэлт гаргасан.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 1
Бүгд: 13
92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 103 дугаар зүйлийн 103.2.2, 103.2.4 дэх заалтын “Сахилгын хорооны” гэснийг тус тус, 103.2.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 0
Бүгд: 13
100 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 105 дугаар зүйлийн 105.2 дахь хэсгийн “энэ хуулийн 105.1-д зааснаас бусад тохиолдолд” гэснийг хасаж, 105.4 дэх хэсгийн “энэ хуулийн 105.2, 106.11-д зааснаас” гэснийг “сахилгын хэрэг үүсгэх тухай болон Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамжаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 0
Бүгд: 13
100 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 106 дугаар зүйлийн 106.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 106.13 дахь хэсэг нэмэх:

“106.6.Илтгэгч гишүүн дараах үндэслэлээр сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг захирамж гарган түдгэлзүүлнэ:

106.6.1.сахилгын хэргийн оролцогч хүнд өвчний учир эмчлүүлж байгаа бөгөөд төлөөлөгч томилох боломжгүй;

106.6.2.сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэсэн;

106.6.3.энэ хуулийн 107.7-д заасан ажиллагаа явуулж байгаа;

106.6.4.холбогдох шүүгчид үүсгэсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхээс өмнө сахилгын хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй;

106.6.5.энэ хуулийн 109.1-д заасан ажиллагаа явуулж байгаа.”

“106.13.Энэ хуулийн 106.6-д заасан түдгэлзүүлсэн үндэслэл арилсан бол илтгэгч гишүүн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	1
Бүгд:	13

92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 108 дугаар зүйлийн 108.3 дахь хэсгийн “баталгаажуулна” гэснийг “баталгаажуулах, эсхүл хуульд заасны дагуу цахим хэлбэрээр өгч болно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	2
Бүгд:	13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 116 дугаар зүйлийн 116.4 дэх хэсгийн “эсэргүүцлийг” гэсний дараа “танхим харгалзахгүйгээр” гэж нэмж, 116.7 дахь хэсгийн “татгалзлын үндэслэл, шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтыг шинжлэх” гэснийг “татгалзлыг хянан үзэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	2
Бүгд:	13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Найруулгын санал

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “оролцох,” гэсний дараа “тухайлсан” гэж, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн

“цалин” гэсний дараа “хөлс” гэж, 107 дугаар зүйлийн 107.16.1 дэх заалтын “үүргээ” гэсний өмнө “албан” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.11 дэх хэсгийн “уламжилж, батлуулна” гэснийг “уламжилна” гэж, 12 дугаар зүйлийн 12.5, 12.6 дахь хэсгийн “хүн, хуулийн этгээдийн” гэснийг “байгууллага, хувь хүний” гэж, 15 дугаар зүйлийн 15.4, 15.5 дахь хэсгийн “түүнийг” гэснийг “түүний албан үүргийг” гэж, “орлоно” гэснийг “орлон гүйцэтгэнэ” гэж, 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтын “бүрэлдэхүүнд орох шүүгчийг” гэснийг “шүүгч гишүүнийг” гэж, 20.12 дахь хэсгийн “сонгох бөгөөд даргыг” гэснийг “сонгож, Комиссын даргыг” гэж, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн “ёсоор” гэснийг “бичгээр” гэж, 36.8 дахь хэсгийн “шүүгчид нэр дэвшээгүй” гэснийг “шүүгчийг сонгоогүй” гэж, 40 дүгээр зүйлийн 40.2.3 дахь заалтын “өөрийн хүсэлтээр энэ хуулийн 39.1-д зааснаас” гэснийг “Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны гишүүнээр сонгогдсоноос” гэж, 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “аль нэг намаас” гэснийг “нам, эвслээс” гэж, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсгийн “системийн тусламжтайгаар” гэснийг “цахимаар эрэмбэлэн” гэж, 64.3 дахь хэсгийн “системд” гэснийг “цахимаар” гэж, 75 дугаар зүйлийн 75.1.1 дэх заалтын “нэгтгэн Засгийн газартай зөвшилцөн Улсын Их Хуралд уламжлах” гэснийг “энэ хуулийн 46.8-д заасан журмын дагуу хүргүүлэх” гэж, 78 дугаар зүйлийн 78.17 дахь хэсгийн “тогтоол” гэснийг “шийдвэр” гэж, 78.4.1 дэх заалтын “шаардлагыг” гэснийг “баримт бичгийн бүрдүүлбэрийг” гэж, 87 дугаар зүйлийн 87.1.3 дахь заалтын “хөдөлмөр зохион байгуулалт,” гэснийг “хөдөлмөрийн” гэж, 104 дүгээр зүйлийн 104.1 дэх хэсгийн “Сахилгын зөрчил гарсан” гэснийг “Шүүгчийг сахилгын зөрчил гаргасан” гэж, 107 дугаар зүйлийн 107.10 дахь хэсгийн “баримт нотлох чадвараа алдах” гэснийг “баримтад тооцохгүй” гэж, 115 дугаар зүйлийн 115.4 дэх хэсгийн “шүүгчид” гэснийг “гишүүнд” гэж, төслийн “шүүгч биш гишүүн” гэснийг “шүүгч бус гишүүн” гэж тохиолдол бүрд өөрчлөх.

3.Төслийн 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсгийн “ажиллах” гэснийг, 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалтын “өөрийн хүсэлтээр” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.7.3 дахь заалт, 34.12 дахь хэсгийн “хөндлөнгийн” гэснийг, 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсгийн “сургалтад суух” гэснийг, 45 дугаар зүйлийн 45.8 дахь хэсгийн “бүхий л” гэснийг, 73 дугаар зүйлийн 73.1.1 дэх заалтын “хангалтыг зохион байгуулах,” гэснийг, 74 дүгээр зүйлийн 74.1.1 дэх заалтын “тодорхой” гэснийг, 75 дугаар зүйлийн 75.2 дахь хэсгийн “байнгын болон нүүдэллэн ажиллах” гэснийг, 84 дүгээр зүйлийн 84.1.3 дахь заалтын “болон өөр ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	0
Бүгд:	13

100 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаарх саналын томъёолол

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “олгохгүй.” гэж,” гэсний дараа “119 дүгээр зүйлийн 119.3 дахь хэсэг, 167 дугаар зүйлийн 167.4 дэх хэсгийн “7” гэснийг “14” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн ““Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 59.1.5-д заасан үндэслэлээр огцруулсан, 59.6-д заасны дагуу огцорсонд тооцсон,” гэснийг “шүүгч Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан огцруулах сахилгын шийтгэл хүлээсэн, эсхүл огцорсонд тооцогдсон,”” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 0
Бүгд: 13
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн талаарх саналын томьёолол

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “тайлбар” гэснийг “мэдүүлэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 1
Бүгд: 13
92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн “томилогдсон” гэсний дараа “шүүгчийн бүрэн эрхийг энэ хууль хөндөхгүй бөгөөд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 1
Бүгд: 13
92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 46.2-т заасан нэмэгдлийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн “49.7 дахь” гэснийг “48.9 дэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 15 дугаар зүйл нэмэх:

“15 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болж дагаж мөрдөхөөс өмнө Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргасан хэрэг, маргаанд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 25.7.5 дахь заалт хамаарахгүй бөгөөд хэрэг, маргааныг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, энэхүү хуультай холбогдуулан баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө дагаж мөрдөж байсан хуулиар хянан шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 16 дугаар зүйл нэмэх:

“16 дугаар зүйл.2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр баталсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23.2-т заасан бүх шатны шүүхийн шүүгчийн цалингийн нэмэгдэлтэй холбогдох заалтыг 2021 оны төсвийн жил дуусах хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Д.Мөнхтуяа, Б.Ундрах, Д.Эрдэнэбалсүрэн, Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Амардэлгэр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач О.Мөнхсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Хонгорзул, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйл дээр Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг зүйл тус бүрээр хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Гурав.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай ажлын хэсгийн танилцуулга болон эцсийн хувилбарын төслийг гишүүдэд тараасан байгаа. Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр танилцуулна.

Б.Энхбаяр: Байнгын хорооны эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 01 дүгээр сарын 7, 8-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ. Ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дөчин хоёрдугаар зүйлийн дөчин хоёрын хоёрын нэг, дөчин хоёрын хоёрын гуравт заасны дагуу холбогдох зарчмын зөрүүтэй саналуудыг боловсруулан танилцуулж байна. Тухайлбал шүүгчийн хараат бус байдлын нэг баталгаа болсон шүүгчийн цалин, түүний нэмэгдлийг хуулийн төсөлд тодорхой тусгах, шүүхийн сахилгын хорооны гишүүнийг чөлөөлөх үндэслэлийг тусгах болон хуулийн төслийн уялдааг хангах саналыг тус тус гаргалаа.

Улсын дээд шүүхийн шүүгчийг Улсын Их Хуралд танилцуулах талаарх төслийн заалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд шилжүүлэх, үүнтэй уялдуулан Нийтийн сонголын тухай хуульд холбогдох өөрчлөлтийг оруулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн сонголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу боловсруулж та бүхэнд тараасан байгаа. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай, Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Түүнчлэн төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж төсөлд тусгасан бөгөөд нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хувилбарын төслийг бэлтгэж та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэж, шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтан танилцуулъя. Лхүндэвийн Атарцэцэг шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Дашдоржийн Мөнхтуяа улсын дээд шүүхийн шүүгч, Цэндийн Цогт улсын дээд шүүхийн шүүгч, Барсүрэнгийн Баасандорж Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль зүйн бодлогын газрын дарга, Шагдарсүрэнгийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч, Одонхүүгийн Мөнхсайхан Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор ийм хүмүүс оролцож байна. Танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн.

Д.Ганбат: Энэ шүүхийн тухай багц хууль маань нэлээн олон түмний хүлээлттэй Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн дагуу хийгдэж байгаа. Энэ одоо засаглалын тулгуур зарчим болох шүүх засаглалыг ямар ч байсан нэг арай дээшлүүлсэн байранд аваачиж тавьсан ийм хууль болох байх гэсэн ийм хүлээлт олон түмний дунд ер нь ард түмний дунд бүх бүх хүмүүсийн дунд байна л даа. Хангалттай л одоо попорлоо. Хангалттай л одоо гадагшаа, дотогшоо янз бүрийн зүйл ярилаа. Тэгээд яг энэ амьдрал дээр гараад ирэхээр энэ хууль маань бас ямар байх вэ гэдэг асуудал. Шүүх гэдэг маань ганцхан шүүх биш л дээ. Бас шүүгчээс бүрдэнэ. Яриад байгаа шүү дээ. Одоо хуулиуд шүүгч бол ярьдаг хууль юм. Хууль бол ярьдаггүй шүүх юм гээд байгаа юм.

Тэгээд саяын энэ танилцуулга дээр өмнө нь одоо хоёр мянга арван таван онд миний үед Хууль зүйн байнгын хорооны дарга байхад Ардчилсан нам байхад бол шүүгч нарын цалинг бол боломжийн хэмжээнд нэмсэн юм. Энийг одоо тэгээд бас нийгэм маань ойлгодоггүй юм. Энэний ач холбогдол нь цаашаа ямар байдаг вэ гэдгийг мэдэхгүй. Шүүгч нар маань бас олон эрхээ хасуулдаг л даа. Нийгэмд бол шударга ёсыг тогтоохын тулд ингэж ажиллахдаа бол. Тэгээд яг төрийн албан хаагч гэж үзээд байна уу шүүгч нараа. Яг юу гэж үзэж энэ цалин, ажиллах орчныг нь бүрдүүлэх дээр хандаад байна. Яаж хандаж байгаа вэ? Тэр хандлагаа нэг гаргачхаач. Нэг болохоор одоо төрийн албан хаагч шиг үзээд байдаг, нэг болохоор арай онцгой субъект маягтай ингэж хараад байдаг. Энийг одоо дунд нь ингэж орхигдуулмааргүй байгаа юм.

Өмнө нь бол одоо бид бүхэн бол ерөөсөө шүүх, шүүгч бол тэр засаглалын тулгийн гурван чулууны нэг мөн. Тэрэнд нь хүрэх ёстой гэж ажилладаг байсан. Одоо арай л өөр маягаар хандаж, арай илүү өөр маягаар ажиллаад байна уу? Эцсийн эцэст энэ ямар байх ёстой юм бэ? Энийгээ эхлээд гаргачихмаар байгаа юм. Тэгэхгүй бол баахан ингээд нэмэгдэл өгч байна барьж байна гээд төрийн албан хаагч ингээд явдаг. Тэр нь бас болж байна уу, болохгүй байна уу? Тэгээд хангалттай энэ чуулган дээр, Байнгын хорооны хурал дээр шүүгч гэдэг хүн маань одоо хязгааргүй их цалин авдаг юм шиг ингээд сурталчлаад байна л даа. Найман сая төгрөг авдаг энэ тэр гээд. Тэрэнд нь одоо хэн ч хариулт өгөхгүй юм. Шүүхийн ерөнхий зөвлөл нь ч өгөхгүй юм. Ажлын хэсгээс энэ ажлын хэсгийн ахлагч нэг хаана нэг үг хэлэх юм. Энийгээ нэг олон нийтийн өмнө ойлгомжтой болго. Энэнээсээ авхуулаад л шүүх, шүүгчийн нэр хүндийг унагаж байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ, шүүгч төрийн албан хаагч мөн үү? Цалинтай холбоотой асуудал дээр ярьсан. Шүүхийн ерөнхий зөвлөл хариулъя. Ер нь бол чуулганы хуралдаанд бас нэлээн яригдсан шүү дээ. Гишүүд бас зөв мэдээлэл өгөөд байсан уу, буруу мэдээлэл өгөөд байсан уу? Тухайлах юм бол одоо Аюурсайхан гишүүн бол маш өндөр цалин авдаг гээд л, Чинзориг гишүүн ингээд бас хэд хэдэн гишүүд одоо өндөр цалин авдаг, өндөр тэтгэвэр тогтоолгох нь гээд яриад байсан. Яг энэ нэг асуудлаа нэгтгээд нэг хариулчих. Үнэн зөв мэдээллээ ард иргэд өгөх ёстой. Бид нар бас. Нэгдүгээр микрофон.

Л.Атарцэцэг: Гишүүдийн өглөөний амар амгаланг айлтгая. Ганбат гишүүнд баярлалаа. Маш чухал бидний тухайн үед үгээ хэлэх боломжгүй байсан асуудлыг хөндөж, бас боломж олгож байгаад би бас их баярлаж байна. Шүүхийн Нэгдсэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан дээр одоо бас бид ингээд нөгөө дэгийнхээ дагуу үг хэлэх боломж нь жоохон юу юм байна лээ. Тэгээд шүүгч, төрийн албан хаагч юм уу гэдэг асуудал нь бол төрийн албаны тухай хуулиараа маш тодорхой

зохицуулалттай. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийнхаа хэмжээнд бид шүүгчид маань төрийн тусгай албан хаагчдын статустай явдаг. Энэ утгаараа бид нар төрийн тусгай албан хаагчийнхаа цалин хангамж, эдийн засгийн баталгаа, нийгмийн баталгаа нь Төрийн албаны тухай хууль болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулагдаж явж байгаа юм. Тэгэхээр энэ цалингийн асуудал бол бид нар Төрийн албаны тухай хуулийн тавин долоодугаар зүйлийн хоёрын гурав дахь зохицуулалт одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар одоо бол шүүгчийн цалингийн цалин дээр нэмэгдлийн асуудал бол Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хорин гуравдугаар зүйлд заасан таван жилээс эхлэн тав дахь жилээс эхлэн жил болгон хоёр хувиар нэмэгдэж явна гэсэн ганц ийм нэмэгдэлтэй явж байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ хуулийг хуулийн төслийг бичих явцдаа боловсруулах явцдаа нэгэнт төрийн албан хаагч, төрийн тусгай албан хаагч учраас энэ Төрийн албаны хуульдаа нийцүүлж нэмэгдлээ бол тооцуулж авах нь зөв юм. Одоогийн Монгол Улсад ажиллаж байгаа таван зуун арван найман шүүгчээс далан таван шүүгч өнөөдөр төрийн албанд ажиллаж байсан хугацаагаар ингээд хязгаарлуулаад шүүгч болохоороо энэ нэмэгдлээ бол ерөөсөө авч чаддаггүй ийм байдалтай, ийм тэнцвэргүй байдал үүсээд байгаа юм. Тэгэхээр бид нар энэ дээр энэ нэмэгдлийн асуудлыг яриад байгаа юм. Тэгээд ер нь бол зүгээр цалингийн тухайд үнэн бодитой мэдээлэл өгөх нь зүйтэй гэдэгтэй бүр санал нэг байна. Тэгээд ер нь одоо шүүгчийн цалингийн асуудал шиг ер нь ингэж ил тод яригдаж, нийгэмд шуугиан үүсдэг ийм албан тушаалтан зүгээр би сайн мэдэхгүй байна. Өнөөдөр шүүгчдийн цалин бол найм, есөн сая төгрөг авдаг цалинтай шүүгч бол байхгүй. Бид нар энэ шүүгчдийн цалингийн нэмэгдлийн асуудлыг ярихдаа анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгч болгон дээр ажилласан жилээр нь хуульд заасан, хуулиар Улсын Их Хурлын тогтоолоор тогтоосон цалингийн хэмжээнээс одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн тэр тав дахь жилээс хоёр дахин нэмэгдэл гэдгээр нь шүүгч болгон дээр ингээд гаргаж өгөөд бид нар Засгийн газарт, Улсын Их Хурлын ажлын хэсэгт бол хүргүүлсэн байгаа.

Тухайн үед тэр найм, есөн сая төгрөгөөр одоо шүүгч нар цалинжаад байна гэдэг мэдээллийг хаанаас, хэн ямар зорилготой гаргаж өгснийг бол мэдэхгүй байна. Бид нар энэ дээр яг тухайн үедээ бол үнэхээр няцаалт өгөх боломжгүй байсан юм. Тэгээд энийг бас хөндөж ярьсанд баярлаж байна.

С.Бямбацогт: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Улсын Их Хурал маань хууль тогтоох байгууллага, тэгээд энэ шүүх шүүгч нарыг бол ажиллах боломж нөхцөлөөр хангах үүрэгтэй. Тэгэхээр сая одоо санаатай юм уу санамсаргүйгээр бас л нөгөө шүүх рүүгээ шүүгч рүүгээ дайрдаг ийм байдал одоо хавтгайрсан байна. Уул нь бол одоо энэ хуулийн заалттай шүү дээ. Би бас сая албаны хүний хэлж байгаад бас талархаж байна. Гэхдээ энийгээ бас нэг мөр ойлгомжтой, тэр байдлаар илэрхийлэхгүй л бол хамгийн эцсийн эцэст нөгөө шүүгч рүүгээ ажиллах боломжийг нь хаачихдаг. Энэ хүн маань одоо хамаг юмаа л хасуулдаг барьдаг хүмүүс шүү дээ. Тэгээд яг тэтгэвэрт гарах нөхцөл нь яг жирийн төрийн албан хаагчидтай адилхан байх ёстой гээд ингээд байдаг. Олон жил социализмаар явчихсан нийгэм маань болохоор яг тэрийг нь дэмжээд байдаг. Эцсийн эцэст яг тэрэн дээр тоглолт хийгээд энэ хүмүүсийг шүүгч нарыг хараат байлгах тийм боломжийг нь бий болгочоод. Дараа нь нөгөө шүүх маань шударга ажиллаж чаддаггүй. Ийм юмыг хүссэн зохион байгуулалттай.../минут дуусав/

С.Бямбацогт: бүгд за ингэх баяр ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Б.Энхбаяр: Ганбат даргад баярлалаа, үнэхээр нөгөө шүүгч нарыг найм, есөн сая төгрөгийн айхтар хос цалин авдаг юм байна гээд Их Хурал дээр бас мэдээлэл гараад. Тэгээд олон шүүгч нарын гэр бүлд бас энэнтэй холбоотой маргаан гарсан юм байна лээ. Нөгөө шүүгч нарын эхнэр, нөхөр нь чи ер нь надаас нь их мөнгө нууж байсан байна, хаана зарцуулсан чи алив гээд ерөөсөө шүүгч нар их гомдол мэдүүлсэн. Үүний дараа. Олон гэр бүлд бол бас зөрчил ийм хэрүүл болсон юм байна лээ. Яг анхан шатны шүүхийн гар дээр авч байгаа цалин бол шүүхийн ерөнхий зөвлөлийн өгч байгаагаар хоёр аравны хоёроос хоёр аравны долоон сая төгрөг л гар дээрээ авч байгаа юм байна лээ. Тэгээд энэ бол одоо яг ерөнхий зөвлөлөөс энэ төсвөөс яг өгч байгаа тоо. Тийм учраас бид нар бас энэ шүүгчдийн цалинтай холбоотой асуудлаар бас үндэслэлтэй судалгаатай эх сурвалжтай яримаар юм байна лээ. Баярлалаа.

С.Бямбацогт: Би нэг асуулт асуучихъя, манайхан бас хариулчих. Ажлын хэсэг. Ер нь бас сая анхны хэлэлцүүлэг дээр болон Байнгын хороон дээр дэмжигдсэн саналууд маань чуулган дээр очоод бас унасан. Ялангуяа шүүгч ч нийгмийн асуудалтай цалинтай тэтгэвэртэй холбоотой асуудлууд. Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бид нар хийхдээ ерөөсөө л иргэдийнхээ шударга шүүхээр шүүлгэх шударга ёсыг тогтоох эрх, эрх чөлөөг хангах энэ баталгааг л хангахыг зорьсон. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд одоо шүүхтэй холбоотой орсон нэмэлт, өөрчлөлт бол. Угаасаа шүүгч өөрөө шүүх тусдаа засаглал, тийм. Шүүгч чинь өөрөө бас онцлогтой, албан тушаалтан. Хэнээс ч араат бусаар шударгаар өөр одоо ямар нэгэн ашиг сонирхол автахгүйгээр аж ахуйн үйл ажиллагаа, бизнес эрхлэхгүйгээр зөвхөн л одоо шударга ёсыг тогтоох нь л ажиллах ёстой. Энэ хүрээндээ бид нар тийм үү, тийм үүднээс энэ одоо ийм онцлогтой албан тушаалтан учраас энэ шүүгч нарын нийгмийн асуудлыг цалингийн асуудлыг бас онцгойлж харж үздэг. Урд нь ч тийм байсан, одоо ч энэ жишгээр явж байгаа. Яг энэ хүрээндээ бас илүү одоо анхаарах ёстой гээд нэмэлтүүд ярьсан нь уначихлаа. Ажлын хэсэг дээр нэмэгдэхээр орж ирсэн үү, орж ирээгүй юу?

Хараат бус байж байж эдийн засгийн баталгаатай байж, нийгмийн асуудлаа шийдүүлж байж шударга ёсыг тогтооно шүү дээ бас. Тийм болохоор нэг талаасаа төр, ард түмэн бол шударга бай, зарчимтай бай, хараат бус бай гээд шаардлага тавьдаг. Нөгөө талаасаа хариуцлага ярьж байгаа сахилгын хороо бараг хариуцлага ярьж байгаа. Хамгийн гол нь одоо эдийн засгийн баталгаа, нийгмийн асуудлыг шийдэх тал дээр Үндсэн хууль ч байж байгаа. Үндсэн хуулийн шүүх улсын төсвөөс санхүүжнэ, шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төрөөс хангаж өгнө гэсэн үүрэгтэй. Энэ Үндсэн хуулийн заалтыг л бид нар хэрэгжүүлэх гэж байгаа юм. Энэ заалтууд маань хамгийн гол нь чуулган дээр бас уначихсан. Энэтэй холбоотой ажлын хэсэг эргүүлж оруулж ирж байгаа юу? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч. Энхбаяр гишүүн хариулах уу.

Б.Энхбаяр: Анхны хэлэлцүүлгийн явцад бас чуулган дээр Чинзориг, Аюурсайхан нарын гишүүд бас санал гаргаад энэ хоёр асуудлыг бол онцолсон. Нэгдүгээрт шүүгчийн тэтгэвэрт гарахыг бол энэ цалин хөлсийг наян хувиар тооцож олгож болохгүй. Энэ одоо нийгмийн даатгалаас сангаас тэтгэвэр тэтгэмж олгох тухай хуультайгаа нийцэхгүй байна гэдэг асуудлыг нэгдүгээрт ярьсан. Хоёрдугаарт цалин дээр бол бусад төрийн албан хаагчдад байдаггүй. Өөрөөр хэлбэл таван жилээс дээш

ажилласан жил тутамд хоёр хувийн нэмэгдэл олгох заалт байсан. Энэ бол одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд байгаа заалт. Хоёр хувь нэмэгдэл. Одоо шүүгч нар авч байгаа ийм нэмэгдэл байгаад байгаа юм. Тэгээд энэ бол бусад хуультай нийцэхгүй байна гээд дэмжлэг аваагүй.

Гуравдугаарт энэ ажлын хэсгээс анхнаасаа энэ зэрэг дэвийн нэмэгдэл олгоё гэдэг заалтыг нь ажлын хэсэг угаасаа хасъя гээд шүүгч нарыг энэ дотор нь бас ингэж эрэмбэлж болохгүй. Том бага дарга цэрэг гэж дотор нь эрэмбэлж болохгүй ийм зэрэг дэвтэй байж болохгүй гээд хасчихсан юм. Тэгээд ингээд зэрэг дэвийн нэмэгдэл байхгүй. Тэгээд сүүлдээ энэ анхны хэлэлцүүлгийн дараа яг Бямбацогт даргын яг хэлж байгаа ийм асуудал үүссэн юм. Шүүгч нарын дунд ч гэсэн нэлээн асуудал үүссэн. За ажлын хэсгийн ахлагч одоо миний нэр дээр бол ер нь бараг бараг бүх аймаг, дүүргийн шүүгч нарын хурал хийгээд ийм мэдэгдэл шаардлагууд бас ирүүлээд байгаа юм. Өөрөөр хэлбэл одоо авч байгаа нөгөө нэмэгдлийг нь хасах ийм одоо байдалтай болчихсон. Тэгэхдээ нөгөө шүүгчийн чинь цалин хөлсийг бид бас бууруулж болохгүй ийм үүрэгтэй. Таны хэлсэнчлэн нөгөө үнэхээр бие даасан эрх мэдэл энэ бол.

Тэгээд нөгөө Засгийн газар одоо бүр бусад бүх институтээ хянаж байгаа, эцсийн шийдвэр, гаргаж байгаа ийм институтийг бид бас цалин, одоо бүр авч байгаа байдлыг нь дордуулж болохгүй гэдэг агуулгаар хоёр хувийнх нь нэмэгдлийг нь бол хасчихъя. Зэрэг дэвийг бол одоо хассанаараа явъя. Наян хувийн тэтгэврийг бол хасъя гишүүдээс бас гаргасан саналыг хүлээж авсан. Ингээд бусад төрийн албанд байгаа буюу бусад төрийн тусгай албан хаагчдад байдаг нэмэгдлийг нь харин бичье. Энд бол ажилласан жилийн нэмэгдлийг таваас хорин таван хувиар, өөрөөр хэлбэл таван жил тутам таван хувь. Энэ бол бусад бүх төрийн албан хаагчид байгаа нэмэгдэл. Мөн онцгой нөхцөлийн нэмэгдэл гэж байдаг. Төрийн албан хаагчдад. Энэ бол нэг гучин таваас дөчин хувь байдаг. Жишээлбэл Авлигатай тэмцэх газрын албан хаагчид бол дөчин хувийн нэмэгдэл авдаг онцгой нөхцөлийн. Тэгэхдээ яах в энэ хэрэв гишүүд дэмжвэл энэ дөчин хувь болох боломжтой.

Ажлын хэсгийн гишүүд бол ярилцаад ямар ч тохиолдолд одоо авч байгаа цалинг бол бууруулж болохгүй. Энэ бол бүр хатуу зарчим. Гучин хувь гэхээр бол нэг зуу гаруй шүүгчдийн цалин буурах гээд байгаа юм. Онцгой нөхцөлийн нэмэгдлийг нь гучин хувь хүрчихээр. Тэгэхээр гучин таван хувь байж байж нэг ч шүүгчийн одоо авч байгаа цалин буурахгүй юм байна гэдэг хувилбарыг Байнгын хорооны гишүүдэд одоо танилцуулж байгаа. Тэгээд та бүхнийг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

С.Бямбацогт: Атарцэцэг гишүүн ажлын хэсэг хариулчхаад дараа нь Алтанхуяг гишүүн ажлын хэсэгт нэмж хариулах уу. Тэгье.

Л.Атарцэцэг: Би зүгээр нэмээд энэ нөгөө шүүхийн ерөнхий зөвлөлөөс бид нар энэ гаргасан тооцоогоо үндэслээд одоо яг ямар тохиолдол байх юм бол энэ шүүгчийн өнөөдрийн энэ хоёр хувийн нэмэгдэлтэйгээ авч байгаа цалин буурахгүй байх вэ гэдэг тооцоог бид нар их олон янзаар хийж үзсэн л дээ. Зүгээр шүүхийн ерөнхий зөвлөлөөс анхны тэр нөгөө шүүхийн тухай хуульд байгаа одоо энэ засгийн газрын төслийг дэмжье гэсэн байр суурьтай явж байсан юм. Ингээд бид нар тооцоогоо ингээд гаргангуут энэ маань нэг шүүгчийн ерөнхий цалингийн дунджийн тооцоог бол бид нар бас гаргасан. Дараагаар нь өчигдөр ажлын хэсгээс бид нарт одоо шүүхийн ерөнхий зөвлөлөөс энэ шүүгчдийн цалинг энэ зэрэг дэвийн нэмэгдэл гэдэг юманд байх нь зохимжгүй юм байна.

Ингээд ер нь онцгой ажлын нэмэгдлийнхээ хувийг жоохон ойртуулаад ингээд үзвэл яасан юм гэдгээр дөчин хувь гэдэг дээр бид нар тооцоо хийж гаргаж үзсэн юм.

Ингээд энэ дөчин хувь гэдэг дээр бид нар тооцоо гаргаад үзэх юм бол одоогийн энэ Засгийн газрын төсөл дээр байгаа энэ зэрэг дэв онцгой ажил төрийн албаны тухай нэмэгдэл гэдэг энэ нэмэгдлийнхээ дүн рүү нэлээн дөхөж очоод байгаа юм. Тэгэхээр бид нар нэгэнт одоо ингээд ажлын хэсгээс зэрэг дэв гэдэг нь одоо дэмий юм, зохимжгүй юм. Үг хэллэгийн тухайд бол бас нэг нийтэд ойлгогдохдоо нэг тийм онцгүй байдлаар буугаад байна гэж ингэж үзэх юм бол энэ онцгой ажлын дөчин хувь гэдэг дээрээ ер нь яривал яасан юм бэ гэдэг дээр бид нар шүүхийн ерөнхий зөвлөл, нийт шүүгчдээсээ бас санал авсан л даа. Ер нь бололцооныхоо хэмжээнд. Тэгээд яг Энхбаяр гишүүнд бас мессеж ирүүлж байгаатай адилхан. Бидэнд ч бас одоо ер нь энэ чинь бууруулж болохгүй шүү. Ядаж энэ чинь одоо дөч, тавь гэсэн их л олон хувь ярьж байгаа л даа.

Тэгээд ингээд бид нар өчигдөр суугаад 20, 25, 30, 35, 40 гэдэг хувилбараар бид нар бүх тооцоогоо гаргачихсан байж байгаа. Ингээд ерөөсөө хамгийн нэг бололцооны хувилбар нь одоо бол дөч гэдэг тоо гараад байгаа юм. Ингээд ер нь гучин таваар байсан ч дөчөөр байсан ч ер нь нэг хэсэг шүүгчдийн цалин бол буурч байгаа. Энэ маань буурч байгаа тоо нь хэд вэ гэхээр нөгөө гучин нэгээс гучин таван жил ажилласан, хорин ес дэх жилдээ ажиллаж байгаа, гучин жил ажиллаж байгаа, одоо анхан болон давж заалдах шатны шүүхэд нийтдээ нэг найман шүүгч байгаа юм. Дээд шатны шүүхэд одоо ажиллаж байгаа нэг дөрөв, таван шүүгч байгаа байх. Тав зургаа. Одоо бид тэр энэ яг ажилласан жилээр нь хяналтын шатны шүүхийн тоог ингээд нэмээд хэлэх юм бол одоо яг онцгой ажлын нэмэгдэл нь жаран хувиар байх юм бол өнөөдөр нэг гучин таван хувиар байх юм бол тэр шүүгчдийн цалин дөрвөн зуун гучин зургаагаас таван зуун хорин хоёр төгрөгөөр буурч байгаа юм. Хорин ес дэх жилдээ ажиллаж байгаа шүүгчдийнх 87, 175 гээд. Хэрэв дөчин хувь байх юм бол энэ шүүгчдийн цалин нэг бас тийм, үгүй ээ, хэвийн хэмжээгээр биш. Яг энэ найман шүүгчдийнхээ тухайд бол буурч байгаа.

Тэгэхдээ бид нар болж өгвөл дөчин хувиар нь байлгаад, за одоо дүүрчээ. Одоо энэ хорин нэгэн оноо дуустал хоёр хувийнхаа нэмэгдэлтэй авах юм байна. Дараа нь ингээд нэг одоо энэ найман шүүгч, арваад шүүгч одоо нэг арав гаруй шүүгч болно. Эд нарын цалин бол нэг зуугаас хоёр зуугаар ингээд за бараг зарим нь ингээд олон жил ажилласан нь ингээд буулаа гэж бодоход нэг нийт массаа ингээд бас нөгөө төрийн албанд ажиллаж байгаа, анх шүүгч болсон шүүгчид маань арай тэгш байдалтай болоод Төрийн албаныхаа тухай хуульд заасан зохих нэмэгдлүүдийнхээ хэсгийг нь ч гэсэн бид нар авчих юм уу даа гэсэн ийм л тооцоо гараад байгаа юм. Тэгэхээр бид нар бол нэг гучин тав, дөч гэсэн хоёр тоон дээр яригдаж байна. Болж өгвөл дөч рүү орох юм бол бид нарын бас нэг одоогийн байдал арай дордохгүй, арай бас нэг дээшилж гарах юм шүү л гэж ингэж л хэлэх байна.

С.Бямбацогт: Ажлын хэсэг Алтанхуяг гишүүн нэмж хариулах уу та. Алтанхуяг гишүүн ажлын хэсгийн гишүүн хариулъя.

Н.Алтанхуяг: Манай Байнгын хорооны гишүүд өчигдөр би энэ 40-г чинь будилуулчихсан хүн би байгаа юм. Ажлын хэсэг дээр. Яагаад тэгсэн юм гэхээр энэ хоёр хувийг нь ингээд Их Хурлын ч юу чуулган дээр алга болгочихсон. Зэрэг дэвийг нь бид нар ер нь бас буруу юм байна гээд алга болгочихсон юм. Тэгээд би зөвхөн хоёр хувиар

нь бодоод байсан чинь зэрэг дэв гээд бас нэг мөнгө өгдөг байсан юм байна лээ. Тодорхой хуваарь гучин тав хүртэл үү Атарцэцэгээ? Гучин таван хувь хүртэл. Тэгэхээр энийг нь оруулах юм бол дөч нь бол боломжийн тоо юм байна лээ. Нэг их өсгөөд авчихгүй. Тэгэхдээ тэр нэг цөөхөн хүнийх нь бол жаахан буурсан байдалтай ийм. Ингээд энэ дөчөөр нь одоо дэмжээд өгвөл зүгээр юм гэж би одоо манай Байнгын хорооны гишүүдэд хэлж байгаа юм, нэг.

Хоёрдугаарт ер нь энэ шүүхийн тухай хуулийг бид нар одоо сайжруулж байна. Шүүхийн хараат бус байдлыг нэмэгдүүлснээрээ нэг хэдэн шүүгчдийнхээ цалинг доошоо буулгачихдаг тийм байж болохгүй. Тэгэхээр одоо би Атарцэцэгээс асуух гээд байгаа юм. Дөч гэдгээр чинь бид нар дэмжээд явбал асуудал гарахгүй болж байгаа биз дээ гэж болж байгаа юу ер нь? Тэрэн дээр хариулт өгөөрэй. Сүүлд нь бид нарийн тооцоон дээр суугаагүй шүү дээ. Энэ шүүхийн ерөнхий зөвлөл суугаад л болж байна, болохгүй байна гэдэг юм хэлж байгаа юм. Хоёрдугаарт ер нь манай гишүүд нэг юм анхаарчих хэрэгтэй. Энэ хуулийн дагуу бол бид нар шүүхийн төсвийг манай Байнгын хороо эхэлж ярьдаг болж байгаа юм шүү. Одоо нэг Сангийн яамны, Сангийн нэг сайдын карманд очоод орчихдог, тэрнээс юм гуйгаад явж байдаг ийм засаглалын нэг мөчир салаа байж болохгүй юм байгаа. Тийм учраас манай Байнгын хороон дээр бид нар одоо төсвөө яриад тэгээд буцаагаад засаг руу өгдөг ийм одоо бас хууль явж байгаа.

Тэгэхээр энэ хууль батлагдсанаараа би бол манай шүүгчид бие дааж хараат бусаар ажиллах, шүүх засаглал өөрөө шүүх засаглал руугаа жаахан явах иймэрхүү боломж нөхцөлүүд бүрдэх болов уу гэж ингэж бодож байгаа юм. Тэгээд дөчин хувь гэдгийг нь Атарцэцэг э микрофон дөчин бол ок гэдгээ хэлбэл тэгээд манайхан дөчин хувийг нь дэмжиж өгөөрэй л гэж хэлж байна.

С.Бямбацогт: Асуултаа би бас тодруулаад асуучихъя саяын асууж байгаа яах вэ, дөчин хувиар явах юм бол шүүгчдийн цалингийн нэмэгдэл нэг дөч хүртэл хувь байх юм бол дөч хүртэл байна шүү дээ онцгой нөхцөлийн нэмэгдэл чинь байх юм бол одоогийн цалин бол хэвийн хэмжээнд цалин буурахгүй хэвийн хэмжээнд хадгалагдах юм байна. Тэгвэл бас нэг жоохон бид нар нэг шударга шүүхтэй болгочхож байгаа, хараат бус шүүхтэй болох гэж байгаа, иргэдийгээ шударга шүүхээр тийм үү шүүлгэх эрхийг нь хангуулах хангах гэж байгаа. Ингэхийн тулд шүүгч нартаа маш том хариуцлага ярьж байгаа. Сахилгын хороотой болсон дөчин зүйлээр маш тодорхой хориг, юу хязгаарлаж, хориглож өгч байгаа, хийх ёстой үйлдлүүдийг нь. Тэгээд үндсэндээ л их тийм онцгой нөхцөлд ажиллах гэж байгаа л даа. Энэ дээр бусад одоо албан тушаалтантай харьцуулаад үзэх юм бол ямархуу байдлаар онцгой нөхцөлд ажиллах гэж байгаа юм. Энэ дээр Мөнхсайхан багш хариулж өгөөч. Дээрээс нь тэр зэрэг дэвийг нэмээд өгчхөж болохгүй байгаа юм уу? Зэрэг дэвийн нэмэгдлийг.

Тэр анхан шатандаа тэр дотор нь зэрэг дэвтэй байхаа больё. Шүүгч нарыг ангилахаа больё, анхан шатандаа нэг тийм үү тусдаа. Давахынх л тусдаа, хяналтынх тусдаа ийм зэрэг дэвтэй байж болохгүй юу? Ийм байдлаар бас нэг жоохон нэмэгдэл байж болохгүй байсан уу? Энэ дээр ажлын хэсэг нэмж хариулж өгөөч. Мөнхсайхан эхлээд.

О.Мөнхсайхан: Баярлалаа. Тэгэхээр долоон жилийн өмнө МУИС-ийн эдийн засаг, социологи, хуулийн багш нар бид нар баг гараад яг энэ шүүгчийн цалин ямар байх вэ гэдгийг харьцуулж судалж байсан. Тэгээд энэ дээр бол яг шүүгчийн хэмжээнд

одоо ажиллах туршлагатай, мэргэшсэн энэ хуульч бол хувиараа ажиллахад бол тухайн үеийн ханшаар доод тал нь таван саяыг сард олдог гэсэн ийм судалгаа гарч байсан юм. Одоо бол энэ инфляц эд нарыг бодоод зүгээр тэр судалгаатайгаа харьцуулахад бол бараг арван саяд дөхөх юм шиг байгаа юм. Тэгэхээр энийг яагаад хэлж байна вэ гэхээр бид нар шүүгчээр хүний амьдралын чухал ас асуудлыг эцэслэж шийдүүлж байгаа учраас хамгийн мэдлэг чадвартай тэр хуульчдыг одоо хувийн салбарынх шиг татдаггүй юм гэхэд энд юу яригдаж байгаа вэ гэхээр ерөөсөө одоо ар гэртээ үндсэн хэрэгцээндээ санаа зовохгүй ажиллах тэр суурь одоо нөхцөлийг нь хангахад цалинг нь бол бусад төрийн албан хаагчаас арай онцгойгоор.../минут дуусав/

С.Бямбацогт: 2 дугаар микрофон цаг нэмж өгье.

О.Мөнхсайхан: Ер нь бол шүүгч төрийн албан хаагч бол биш. Уг нь Үндсэн хуулийн зарчмаараа. Яагаад вэ гэхээр Үндсэн хуулийн дөчин наймын гурав дээр шүүхийн үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана гэж байгаа юм. Энэ юу гэсэн үг вэ гэхээр төр гэдэг маань гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудыг ойлгодог. Тэгэхээр тусдаа субъект нь төр нь шүүхийн баталгааг хангана гэж байгаа учраас шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа субьектийг бол Үндсэн хуулийн зарчмаар сая Байнгын хорооны даргын хэлдгээр тусгайлан авч үздэг. Өөрөөр хэлбэл төрийн эрх мэдлийн салаа мөчрийн нэгийг нь одоо бие дааж тэр эрх мэдлээ хэрэгжүүлж байгаа учраас онцгойлж авч үзэж байгаа юм.

Тэгээд гуравдугаарт бол шүүх бол маш ачаалалтай. Одоо судалгаагаар бол одоо нийслэлийн шүүгч нар ялангуяа хагас, бүтэн сайнгүй ажилладаг, маш ачаалалтай. Тэгээд зарим хүмүүс бол энийг мушгиад авлига, одоо цалин нэмэхгүй бол авлига авах гэж байгаа гэж мушгиад байгаа юм. Тийм юм ярьж байгаа нэг ч шүүгч байхгүй. Яг судлаад үзэх юм бол шүүгч цалингийнхаа нэлээд хувийг байрны зээл, сургалтын зээлд өгдөг, үндсэн хэрэгцээгээ л хангах хэмжээний ийм цалинг нь хангаж байж шүүх бол одоо санаа зовохгүй ажлаа хийх л тийм л нөхцөл байж байгаа юм. Тэгээд шүүгчийн хувьд бол түрүүн бас хэлсэн, энэ хуулиар өмнө ч гэсэн бол маш их хязгаарлалтуудыг тавьж өгч байдаг. Бид нарын жирийн иргэнийхээ хувьд эдэлдэг нэлээн эрхүүд хязгаарлагддаг, үүрэг хариуцлагууд хүлээгддэг маш ачаалалтай учраас өө ажил хийхийг нь хориглодог учраас ямар нэгэн байдлаар өөр орлого олох боломж байдаггүй. Тэгээд энэ шүүхийн шинэчлэл хийж байгаа пост коммунист улсууд ч гэсэн яг манай өнөөдөр яригдаж байгаа шиг байдлаар тусгайлан шүүгчийнхээ үүрэг хариуцлага, хараат бус байдлын баталгааг эдийн засгийн баталгаатай нь хамт нэмж байж энэ бүх шинэчлэлийн үр дүн гардаг байгаа.

Тэгэхээр энэ талаас нь бас эрхэм гишүүд маань хандаж энэ онцгой байдлын нэмэгдлийг нэмэх санал гаргаж байгааг бол дэмжиж байна. Зэрэг дэвийн хувьд бол харьцуулсан судалгаа хийгээд үзэхээр яг шүүгчдийн хувьд зэрэг дэв байдаг байсан. Тэгэхдээ ер нь бол одоо бараг байхгүй болчихсон. Миний мэдэж байгаагаар Италид л байх шиг байгаа юм. Бусад улсууд бол зэрэг дэвгүй болчхож байгаа. Гол шалтгаан нь бол анхан давахын байна уу, шинээр томилогдсон, хуучин байна одоо ажиллаж байсан гэдгээс үл хамаараад шүүгч л бол шүүгч. Тэрэн дээр ямар нэгэн байдлаар аль нь нэг нь нөгөөгөөсөө илүү гэдэг ялгаа гаргаж хандаж болохгүй гэдэг бас тэр зарчим байж байгаа. Тэгэхээр энэ бол өөрөө иргэний одоо хууль шүүхийн өмнө эрх тэгш байхын эрхийн тэр баталгаа илэрхийлж байгаа. Тэгэхээр зарчмын хувьд бол энэ зэрэг дэвийн ялгаа байхгүй болгоод. Гэхдээ Засгийн газрын өргөн барьсан энэ зэрэг дэвийн

нэмэгдлийг хасаж байгаа юм бол тэр хэмжээгээр нь онцгой байдлын нэмэгдлийг ядаж Авлигатай тэмцэх газрын тэр одоо онцгой нөхцөлийн нэмэгдэлтэй нь дүйцүүлж дөчин хувь болгох нь бол зайлшгүй байгаа юм. Тэгж байж Засгийн газрын өргөн барьсан төслийн одоо цалин нэмэгдлийн тэр агуулга бол буурахгүйгээр одоогийн байж байгаа байдал бол буурахгүйгээр, одоо энэ асуудал шийдэгдэнэ гэж харж байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Атарцэцэг гишүүн нэгдүгээр микрофон. Ажлын хэсэг.

Л.Атарцэцэг: Одоо нэг ийм энэ дөчин хувиар нь ингээд нэмчих юм бол шүүгчид чинь одоо тэр нийгэм эдийн засгийн баталгаа нь хангалттай бол, үгүй ээ, тийм. Үгүй ээ үгүй тийм нөгөө нэмэгдлээ ингэж дөчин хувиар н онцгой ажлын нэмэгдлээ дөчин хувиар нь ингэж тогтоох юм болбол одоо энэ цалин чинь бүхий л одоо тэр нөгөө нийгэм эдийн засгийн баталгаагаа хангахад хүрэлцээтэй юм уу гэдгийг бол бас хэлэхэд их төвөгтэй л дээ. Ер нь бол. Ер нь шүүгчдийн цалин хоёр мянга арван таван оны зуун нэгдүгээр тогтоолоор тогтоосон хоёр сая долоон зуугаас гурван сая хоёр зуугийн хоорондох анхан болон давж заалдах шатны шүүхийн дээд хэмжээ гурван сая хоёр зуу. Энэнээс хойш шүүгчдийн цалингийн яг үндсэн цалин бол ерөөсөө хөдлөөгүй байж байгаа. Тэгэхээр энийг бас бид нар бол одоо цаашдаа шүүхийн ерөнхий зөвлөл шинээр байгуулагдаад шүүгчдийнхээ ажлын ачаалал, одоо энэ хийж байгаа ажлын цалинтай нь харьцуулаад энэ үндсэн цалинг нэмэгдэх тухай асуудал цаашдаа Их Хурлаар яригдах байх гэж ингэж найдаж байна.

Энийг бол одоо шинээр ажилласан шүүхийн ерөнхий зөвлөл бид нар бас анхааруулж хэлнэ гэж ингэж ойлгож байгаа юм. Зүгээр онцгой ажлын нэмэгдлийн дөчин хувь гэдэг бол одоо бид нар тэр нөгөө Засгийн өргөн барьсан төслийн саяхан Мөнхсайхан доктор ярилаа. Нөгөө зэрэг дэвийн нэмэгдэл бид нар хуучнаар Улсын Их Хурлын тогтоолоор хорин таваас гучин таван хувийн нэмэгдэлтэй байсан юм байна. Онцгой ажлын нэмэгдэл арван таван хувийн нэмэгдэлтэй. Ингээд зэрэг дэвийнхээ нэмэгдэл энэ онцгой ажлынхаа нэмэгдлийг ингэхээр нэг дөчөөс тавин хувийн зэрэг дэвийн нэмэгдэлтэй. Дээр нь төрийн албаны нэмэгдлээр таваас хорин таван хувийн нэмэгдэл гээд. Ингээд нэг энэ дүйцсэн тоо руугаа барьчих юм байна даа. Тэгэхээр нэг зэрэг дээрээс татгалзаад байвал энийг маань ядаж бууруулахгүй байх л эхний ээлжид нэг ийм арга хэмжээ авч өгөөч л гэсэн ийм юутай байгаа, саналтай байгаа.

С.Бямбацогт: Цогт шүүгч хариулах гээд байна уу тийм ээ. Дээд шүүхийн шүүгч Цогт. 1-рүү шилжээд суучих, солигдоод.

Ц.Цогт: Сайн байцгаана уу? Энэ шүүгчийн цалинтай холбоотой маш тодорхой тоо би хэлээд өгье. Яагаад гэвэл чуулганы нэгдсэн хуралдаан дээр найман сая, арван нэгэн сая гээд үнэхээрийн одоо байхгүй тийм тоо ярьж олон нийтэд ийм зөрүүтэй мэдээлэл тараасан учраас. Энэ дээр би хоёр одоо дээд, доод, хамгийн доод хоёр хязгаарыг хэлээд өгье. Тэгэхээр нэг жил ажиллаж байгаа шүүгч анхны үндсэн цалин нь 2,5 сая төгрөг. 2,7 сая төгрөг. Ямар ч нэмэгдэл байхгүй. Нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын юу орлогынхоо албан татварыг хасаад анхан шатны нэгээс дөрвөн жил ажиллаж байгаа шүүгч бол гар дээрээ 2 сая 150 мянган төгрөг авч байгаа юм. Энэ бол хамгийн одоо доод анхан шатны хамгийн бага цалин гэсэн үг. Хамгийн өндөр цалинг хяналтын шатанд буюу улсын дээд шүүхэд ажиллаж байгаа нийтдээ гучин нэгээс гучин таван жил ажиллаж байгаа энэ шүүгч үндсэн цалин нь 3,2 сая, нэмэгдэл нь 2,3 сая, нийтлээд бохир цалин нь 5,5 сая, гар дээрээ авч байгаа хамгийн одоо өндөр шүүхийн

шүүгчийн цалин бол 4,5 сая төгрөг байна. Энэ бол гучин таван жил ажиллачихсан, хяналтын шатны шүүхийн шүүгч. Тийм яг өнөөдрийн нөгөө хоёр хувь авч байгаа нэмэгдлээрээ бол хамгийн өндөр цалин авч байгаа шүүгч бол 4,5 сая.

Тэрнээс найман сая төгрөгийн цалинтай, арван нэгэн сая төгрөгийн цалинтай нэг ч шүүгч Монголд байхгүй. Тэгээд энэ асуудлаа шийдэж өгөхгүй бол Үндсэн хууль болоод шүүхийн тухай хуулиар заагдсан шүүгчийн цалинг бууруулж болохгүй гэдэг энэ хуулийн хязгаарлалтыг яах вэ гэдэг асуудал нэгдүгээрт болж байгаа юм. Хоёрдугаарт энэ шүүгчийн нэмэгдэл, цалин нэмэгдэлтэй холбоотой нэг асуудал бол яагаад энэ тусдаа асуудал байх ёстой вэ гэхээр өөр орлого олгох бүх боломжуудыг нь хуулиар хязгаарлаж өгдөг. Багшлах болон эрдэм шинжилгээний ажил хийхээс өөр ямар ч ажил хийж болохгүй. Багшлах эрдэм шинжилгээний ажил хийдэг шүүгч энэ таван зуун шүүгч дотор чинь гарын таван хуруунд хүрэхгүй байгаа. Таваас арван хүн байгаа. Тэгэхээр тийм тэтгэвэрт гарсан хойноо хууль зүйн зөвлөгөө өгч болохгүй. Өмгөөлөл хийж болохгүй ийм хязгаарлалтыг энэ хуулиар зааж өгч байгаа шүү дээ. Тийм учраас энэ хүний тэр ажил, амьдралын онцлог байдлыг хангасан байдлаар цалин хөлснийх нь асуудлыг шийдэж өгөөч гэж Байнгын хорооноос гишүүдээс хүсэж байна.

С.Бямбацогт: Танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалтууд явагдана. Сая 2021 оны 01 дүгээр сарын 07, 08-ны өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн болон ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулъя. Сая унасан саналууд дээр бас тодорхой ярьчихлаа. Тэгье. Одоо Их Хурлын чуулганы хуралдаан даргалагчаас 42.1.1-д заасны дагуу хураалгах санал.

Нэг.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналын томъёолол.

1.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.2 дахь хэсэг нэмэх:

“4.2.Шүүх нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудлыг болон Засгийн газрын улс төрийн шийдвэрийг хянан хэлэлцэхгүй.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж. Энэ Байнгын хороон дээр энэ санал түрүүн бол дэмжигдээгүй. Их Хурал дээр даргалагчаас дахиж наадахаа ярь гэж буцаасан ийм санал байгаа. Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Би бол энэ Пүрэвдорж гишүүний гаргасан саналыг дэмжихгүй байр сууринаас үг хэлж байгаа юм. Өнөөдөр бид нар бас юун дээр Их Хуралд Захиргааны ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өнөөдөр хэлэлцэнэ. Энэ Захиргааны ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гол агуулга юу байгаа вэ гэвэл иргэн төр хоёрыг тэнцвэржүүлж байгаа гол зүйл бол захиргааны хэргийн шүүх. Тийм учраас Засгийн газрын аль шийдвэрийг улс төрийн шийдвэр, аль шийдвэрийг улс төрийн биш шийдвэр гэж ялгахад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж байгаа гэдэг нэг зүйл байгаа. 2-т урд нь яасан бэ гэвэл манай Энх-Амгалан сайд өмнө нь Зам, тээврийн сайд байхад гарч байсан. Томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явцад захиргааны хэргийн шүүх дангаараа нэг шүүгч орж ирээд Засгийн газрын гишүүдийн кабинетаараа

шийдвэрлэсэн шийдвэрийг өөрчлөөд хүчингүй болгоод явчихдаг ийм зүй тогтолтой байсан.

Тэгээд бид Захиргааны ерөнхий хуулиар энийг яаж шийдэж байгаа вэ гэвэл энийг бүрэлдэхүүнтэй шийддэг болъё. Тэгээд Засгийн газрын гаргаж байгаа шийдвэрийг энийг нь улс төрийнх, энийг нь улс төрийн биш шинжтэй шийдвэр гэгийг ялгах боломжгүй байгаа учраас бүрэлдэхүүнийг нь өргөтгөж шийддэг болъё ингээд шийдвэр болгоныг нь захиргааны хэргийн шүүх хянадаг болъё гэсэн ийм зарчимтай явж байгаа. Тэгэхээр энийг бол би дэмжихгүй байгаач гэсэн саналыг хэлэх гэж байгаа юм.

С.Бямбацогт: Дэгээрээ юу юм байна үг хэлэхгүй юм байна. Би үг хэлүүлсэн нь дэг зөрчсөн байна. Одоо саналаа шууд хураагаад явах юм байна. Санал гаргасан Пүрэвдорж гишүүн л үг хэлнэ. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Хууль буцаж хэрэглэгдэхгүй гэдэг зарчмаар одоо энэ Засгийн газрын урд нь гарсан шийдвэрүүд бол энэ хуулийн хүрээнд орохгүй гэж 1 дүгээрт ойлгох хэрэгтэй. 2 дугаарт нь ер нь бол Засгийн газрын улс төрийн шийдвэрийг одоо юу байдаг юм хүүхдийн мөнгө ч юм уу аль эсхүл юу байдаг юм үнэ чөлөөлөх тухай шийдвэр байна шүү дээ. Одоо энэ цахилгаан эрчим хүчний үнэ чөлөөлөх шийдвэр энэ бол улс төрийн шийдвэр байгаа юм. Гэтэл энийг танилцуулсан Засгийн газрын гишүүнийг нь одоо авч яваад хуулийнхан хамтын гаргасан хамтын шийдвэрийг нь танилцуулсан нөхрийг нь одоо гэм буруутай гэж үзээд шийддэг ийм тохиолдол бол хэд хэдэн удаа гарсан.

Тэгэхээр энэ захиргааны ерөнхий хууль өнөөдөр өргөн баригдаад тэр нь хэлэлцэх юм уу хэлэлцэгдэхгүй юм уу. Батлагдах юм уу батлагдахгүй юм уу гэдэг нь бас тодорхой биш л дээ. Тийм учраас энэ 2 тэр хууль дээрээ тэртээ тэргүй улс төрийн шийдвэр гэдгээ яаж тайлбарлах вэ, захиргааны шийдвэр гэдгээ яаж тайлбарлах вэ гэдгээ тодорхой болгож оруулж ирж байгаа юм байна лээ. Энэ бол зөв. Гэхдээ энэ нь шүүхийн хууль дээрээ бас энэ заалтыг тодорхой ингээд бичээд оруулах нь зөв гэж би үзэж байгаа. Тийм учраас гишүүдийг энэ саналыг дэмжиж өгөөч гэсэн ийм л саналыг гаргаж байна. Ер нь бол аль нэг нам улс төрийн хүчин гарч ирдэг. Урд талын Засгийн газрын болон шийдвэрүүдийг гаргаж ирж байгаад нөгөөхөө одоо ялладаг ийм зүйлээс татгалзахгүй бол дунд шатандаа ажил хийдэг энэ Монгол төрийн төлөө зүтгэдэг ийм хүн байхгүй болж эхэлж байна.

Тийм учраас энэ Засгийн газрын хамтын шийдвэр бол тодорхой хэмжээгээр юу байдаг юм иргэний асуудал хөндсөн захиргааны хэм хэмжээний акт мэдээж одоо захиргааны хэргийн шүүх одоо шийдээд явна. Хамгийн гол нь эрүүгийн татаж тэр танилцуулсан сайдыг нь сугалж авч шийддэг энэ зүйлээс л больё гэж энэ саналыг гаргаж байгаа. Тэгэхээр энэ бол өнөөдөр засаг барьж та бүхэнд бас чухал шүү гэдгийг би хэлье.

2 дугаарт нь 27.1.7 дээр би хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гаргасан өргөдөл гомдолд албан бичгээр хариу өгөх гэж нэг зүйл байгаа. Тэрэн дээр иргэний гэдэг үгийг нь хасъя гэсэн тийм юу протоколд оруулаарай. Үг хэлэх боломж гарсан дээр.

С.Бямбацогт: Санал гаргасан гишүүн саналаа тайлбарлаж үг хэллээ. Санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.8.8 дахь заалт нэмэх:

“25.8.8.улс төрийн намын бүртгэл хөтлөх,” санал гаргасан Улсын Их хурлын гишүүн Нямбаатар. Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Энэ санал бол Монгол Улсад цаашаа олон намын тогтолцоо ардчилал бат бөх байх уу үгүй юу гэдгийг л батлан хамгаалах ийм л заалт. Өөрөөр хэлбэл одоо улс төрийн намуудын бүртгэлийг Улсын дээд шүүхийн иргэний танхим дээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хийж байгаа. Тэгээд эрх баригчид шүүхэд цөөхөн тооны шүүгчид нөлөөлөх нөлөөллөөс гаргахын тулд нийт шүүгчдийн бүрэлдэхүүнээрээ энэ улс төрийн намын бүртгэлийг хийе гэж байгаа юм.

28 оноос энэ заалтыг хэрэгжүүлбэ гэж бид нар бас ажлын хэсэг дээр ярьсан. Учир юу вэ гэвэл 28 оноос улс төрийн намуудын тухай хууль шинээр үйлчилж эхлэх Үндсэн хуулийн заалттай. Сая та бид бүгдийн баталдаг хууль тогтоомжийг 24 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл дээр Хууль зүй, дотоод хэргийн яам улс төрийн намын тухай хуулийг боловсруулж батлуулах үүргийг сая энэ тогтоолоор үүрэг хүлээсэн. Энэтэй холбогдоод улс төрийн намуудын хууль батлагдмагц нийт сонгогчдын 1 хувиас доошгүй хэмжээний гишүүнчлэлтэй улс төрийн намын улсын дээд шүүх бүртгэхээр болж ирж байгаа.

Тэгэхээр би бол энийг хуулийг хэрэгжих хугацаа дээрээ тэр хуулийг дагаж мөрдөх журмын хууль дээрээ энэ магадгүй миний энэ оруулж байгаа заалтыг 28 оноос хэрэгжихээр тусгайлан заагаад ингэж оруулж ирэх нь зүйтэй юм. Тэгэхгүй бол өнөөдөр улс төрийн намуудын бүртгэлд эрх баригчид оролцдог. Цаашлаад улс төрийн намын дүрмийг бүртгэхгүй гацаадаг ийм зүйлүүд ерөөсөө үеийн үед үргэлжилсээр л ирсэн. Энийг таслан зогсоох үүднээс улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар улс төрийн намын бүртгэлийг хийх улс төрийн намын дүрмийн өөрчлөлтийг баталгаажуулах гэх мэт энэ тодорхой заалтууд орж ирснээр Монголд улс төрийн нам олон намын тогтолцоо илүү бат бөх тогтвортой болох ийм үндэслэл бүрдэнэ.

Бид нар энэ улсын дээд шүүхийнхээ 24 шүүгчийг бол нийлээд шударга ёс гэж харж байгаа шүү дээ. Гаднын улс орнууд ч гэсэн америкт холбооны дээд шүүхийн шүүгчдээ justice гэж нэрлэж байгаа. Тэгэхээр бид нар энэ шударга ёсонд энэ бүртгэлийг аваачиж хадгалуулъя гэсэн зүйлийг ярьж байгаа юм. Тэрнээс биш сонгуулийн ерөнхий хороо энэ тэр нөгөө намынхаа бүртгэлийг бүртгэнэ бүртгэхгүй гээд байдаг бол аягүй тийм инээдтэй зүйл болно. Тийм учраас шударга ёсонд нийцүүлж улс төрийн намын бүртгэл хийдэг энэ тогтолцоог маань та бүхэн дэмжиж өгөөч. Хэрэгжилтийг нь 28 руу тавьж болох юм.

С.Бямбацогт: Харин санал байдаггүй. Одоо чинь бол улс төрийн намын дүрмээ бүртгэхдээ дээд шүүхэд бүртгүүлдэг. Тамгаа авахдаа улсын бүртгэлийн ерөнхий газраас авдаг. Санхүүгийн тайлангаа үндэсний аудитын газар дээр тайлангаа өгдөг. Тэгээд сонгуулийн ерөнхий хороон дээр очиж улс төрийн сонгуульд оролцохдоо бүртгүүлдэг нэг ийм л замбараагүй л яваад байгаа л даа. Энийг цэгцэлье гэж байгаа.

Уг нь сонгуулийн ерөнхий хороонд гэж ярьж л байсан л даа. Тэгээд энийг өөрчлөөд л явж байгаа юм байна л даа. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Нямбаатар гишүүний саналыг дэмжье гэсэн. Дэмжих юм уу. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 76,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгах саналуудаар санал хураалт явуулъя. Ажлын хэсгээс боловсруулсан. Энэ саналууд дээр бол 2/3-оор батлагдах дэмжигдэх ёстой. Ирцээ гишүүд ажлын алба ирцийн. Санал хураалт явуулах гэж байна шүү гишүүдээ анхааралтай. Гишүүд суусан уу.

Хоёр. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх ажлын хэсгийн саналын томъёолол. Гишүүдээ анхааралтай.

1. Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “гэж” гэсний дараа “эрүү, иргэн, захиргаа зэрэг” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “хэргийн” гэсний дараа “зэрэг” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний санал буюу 76,9 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

2. Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “дөрвөн” гэснийг “хоёр” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 76,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3. Төслийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсгийн “сонгосон” гэсний дараах “шүүгч” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 12 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Пүрэвдорж гишүүн бүгд дээр татгалзаад байна шүү та.

4. Төслийн 20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 20.13 дахь хэсэг нэмэх:

“20.13. Энэ хуулийн 20.2.3-т заасан тайланг Нийт шүүгчийн чуулганаар сонсохдоо хэлэлцүүлэг явуулахгүй бөгөөд дүгнэлт, шийдвэр гаргахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 91,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5. Төслийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.9. Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар гаргасан албан ёсны тайлбар, Улсын дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой гэж үзсэн шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт орсон байна. Сайжирсан байна. Дэмжинэ. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдсэн байна.

6. Төслийн 24 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 24.5 дахь хэсэг нэмэх:

“24.5.Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй хэрэг, маргааны талаар сургалтын хөтөлбөр, арга зүйд тусгахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг, санал байхгүй. Ажлын хэсэг л саналаа тайлбарлана, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Асуултаа түрүүн асуусан шүү. Санал хураалтад 100 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “тухай саналыг Ерөнхийлөгчид, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай албан бичгийг Улсын Их Хуралд холбогдох баримт бичгийн хамт хүргүүлнэ” гэснийг “саналыг, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулснаар томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Дээрх 7 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 36.2, 36.3 дахь хэсэг болгож, 36.2.6 дахь хэсгийг хасах, заалтыг хасах:

“36.2.Улсын Их Хурал Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 104 дүгээр зүйлд заасан журмын дагуу танилцана.

36.3.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 36.2-т заасны дагуу Улсын Их Хурал танилцсан нэр дэвшигчийг долоо хоногийн дотор Улсын дээд шүүхийн шүүгчээр томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. 76,9 хувийн саналаар.

9.Төслийн 46 дугаар зүйлийн гарчгийн “Шүүгчийн” гэсний өмнө “Шүүх,” гэж нэмж, 46.5 дахь хэсгийн “хүндэтгэлийн” гэснийг “хүндэтгэл, энэ хуулийн 15.6-д заасны дагуу томилолтоор ажиллах” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Төслийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 46.7 дахь хэсгийн “журам, шалгуур үзүүлэлтийг” гэснийг “шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журмыг” гэж өөрчлөх:

“46.2.Шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн албанд ажилласан хугацааны, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Анхааралтай. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Дээрх 10 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 47 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 92,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12.Төслийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалтын “өв залгамжлагчид” гэснийг “гэр бүлд” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 48.9 дэх хэсэг нэмэх:

“48.9.Шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гарахад түүний авч байсан сарын дундаж цалингийн хэмжээгээр 36 сарын хугацаагаар тооцож нэг удаагийн тэтгэмж олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Сарын дундаж цалингийн хэмжээ гэж одоо. 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Сарын дундаж цалингийн хэмжээ гэхээр одоо юу гэсэн үг вэ.

13.Төслийн 50 дугаар зүйлийн 50.8 дахь хэсгийн “тухайн шүүгчийг оролцуулан” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

14.Төслийн 58 дугаар зүйлийн 58.1.6 дахь заалтын “51.1.23” гэснийг 58.1.7 дахь заалтад шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15.Төслийн 77 дугаар зүйлийн 77.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“77.10.Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүний албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлс, нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 76,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

16.Төслийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсгийн “дийлэнх” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 92,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

17.Төслийн 96 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 96.21 дэх хэсэг нэмэх:

“96.21.Сахилгын хорооны төсвийг боловсруулж батлахад энэ хуулийн 46.8-д заасан журмыг баримтална.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 92,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

18.Төслийн 98 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 98.4, 98.5 дахь хэсэг нэмэх:

“98.4.Сахилгын хорооны гишүүн энэ хуулийн 44.2-т заасан этгээдтэй уулзсан, харилцсан бөгөөд уг этгээд өөрөө, эсхүл бусдаар дамжуулан аливаа хэлбэрээр нөлөөлсөн, нөлөөлөхөөр оролдсон, үүрэг, чиглэл өгсөн бол энэ талаарх мэдээллийг агуулсан тэмдэглэл үйлдэн Сахилгын хороонд битүүмжлэн ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх үүрэгтэй.

98.5.Сахилгын хороо энэ хуулийн 98.4-т заасны дагуу битүүмжлэн ирүүлсэн тэмдэглэлийг хадгалах бөгөөд Сахилгын хорооны гишүүний өөрийнх нь, эсхүл эрх бүхий байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдэд гарган өгнө.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

19.Төслийн 84 дүгээр зүйлийн 84.9 дэх хэсгийн, 99 дүгээр зүйлийн 99.6 дахь хэсгийн “106.1.1-106.1.4-т заасан эрхийг эдэлнэ” гэснийг “103.1.1, 103.1.2-т заасан эрх эдэлж, 103.2-т заасан үүргийг биелүүлнэ” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 76,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

20.Төслийн 100 дугаар зүйлийн гарчгийн “гишүүнийг” гэсний дараа “чөлөөлөх,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 100.1 дэх хэсэг нэмэх:

“100.1 .Сахилгын хорооны дарга, гишүүнийг дараах үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

100.1.1.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

100.1.2.өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, эрүүл мэндийн байдал, бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

100.1.3.өөрөө хүсэлт гаргасан.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Анхааралтай байгаарай гишүүдээ. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 92,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Төслийн 100 дугаар зүйлийн 103.2.2.

21.Төслийн 103 дугаар зүйлийн 103.2.2, 103.2.4 дэх заалтын “Сахилгын хорооны” гэснийг тус тус, 103.2.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Сэргэлэн гишүүнээ. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

22.Төслийн 105 дугаар зүйлийн 105.2 дахь хэсгийн “энэ хуулийн 105.1-д зааснаас бусад тохиолдолд” гэснийг хасаж, 105.4 дэх хэсгийн “энэ хуулийн 105.2, 106.11-д зааснаас” гэснийг “сахилгын хэрэг үүсгэх тухай болон Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамжаас” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн 100 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Төслийн 106 дугаар зүйлийн 106.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 106.13 дахь хэсэг нэмэх:

106.6.Илтгэгч гишүүн дараах үндэслэлээр сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг захирамж гарган түдгэлзүүлнэ:

106.6.1 .сахилгын хэргийн оролцогч хүнд өвчний учир эмчлүүлж байгаа бөгөөд төлөөлөгч томилох боломжгүй;

106.6.2.сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэсэн;

106.6.3.энэ хуулийн 107.7-д заасан ажиллагаа явуулж байгаа;

106.5.4.холбогдох шүүгчид үүсгэсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхээс өмнө сахилгын хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй;

106.6.5.энэ хуулийн 109.1-д заасан ажиллагаа явуулж байгаа.”

“106.13.Энэ хуулийн 106.6-д заасан түдгэлзүүлсэн үндэслэл арилсан бол илтгэгч гишүүн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 92,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

.Төслийн 108 дугаар зүйлийн 108.3 дахь хэсгийн “баталгаажуулна” гэснийг “баталгаажуулах, эсхүл хуульд заасны дагуу цахим хэлбэрээр өгч болно” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

25.Төслийн 116 дугаар зүйлийн 116.4 дэх хэсгийн “эсэргүүцлийг” гэсний дараа “танхим харгалзахгүйгээр” гэж нэмж, 116.7 дахь хэсгийн “татгалзлын үндэслэл, шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтыг шинжлэх” гэснийг “татгалзлыг хянан үзэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын санал. 3 санал байгаа хамтад нь уншъя. 1.Төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “оролцох,” гэсний дараа “тухайлсан” гэж, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн “цалин” гэсний дараа “хөлс” гэж, 107 дугаар зүйлийн 107.16.1 дэх заалтын “үүргээ” гэсний өмнө “албан” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.11 дэх хэсгийн “уламжилж, батлуулна” гэснийг “уламжилна” гэж, 12 дугаар зүйлийн 12.5, 12.6 дахь хэсгийн “хүн, хуулийн этгээдийн” гэснийг “байгууллага, хувь хүний” гэж, 15 дугаар зүйлийн 15.4, 15.5 дахь хэсгийн “түүнийг” гэснийг “түүний албан үүргийг” гэж, “орлоно” гэснийг “орлон гүйцэтгэнэ” гэж, 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтын “бүрэлдэхүүнд орох шүүгчийг” гэснийг “шүүгч гишүүнийг” гэж, 20.12 дахь хэсгийн “сонгох бөгөөд даргыг” гэснийг “сонгож, Комиссын даргыг” гэж, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн “ёсоор” гэснийг “бичгээр” гэж, 36.8 дахь хэсгийн “шүүгчид нэр дэвшээгүй” гэснийг “шүүгчийг сонгоогүй” гэж, 40 дүгээр зүйлийн 40.2.3 дахь заалтын “өөрийн хүсэлтээр энэ хуулийн 39.1-д зааснаас” гэснийг “Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны гишүүнээр сонгогдсоноос” гэж, 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “аль нэг намаас” гэснийг “нам, эвслээс” гэж, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсгийн “системийн тусламжтайгаар” гэснийг “цахимаар эрэмбэлэн” гэж, 64.3 дахь хэсгийн “системд” гэснийг “цахимаар” гэж, 75 дугаар зүйлийн 75.1.1 дэх заалтын “нэгтгэн Засгийн газартай зөвшилцөн Улсын Их Хуралд уламжлах” гэснийг “энэ хуулийн 46.8-д заасан журмын дагуу хүргүүлэх” гэж, 78 дугаар зүйлийн 78.17 дахь хэсгийн “тогтоол” гэснийг “шийдвэр” гэж, 78.4.1 дэх заалтын “шаардлагыг” гэснийг “баримт бичгийн бүрдүүлбэрийг” гэж, 87 дугаар зүйлийн 87.1.3 дахь заалтын “хөдөлмөр зохион байгуулалт,” гэснийг “хөдөлмөрийн” гэж, 104 дүгээр зүйлийн 104.1 дэх хэсгийн “Сахилгын зөрчил гарсан” гэснийг “Шүүгчийг сахилгын зөрчил гаргасан” гэж, 107 дугаар зүйлийн 107.10 дахь хэсгийн “баримт нотлох чадвараа алдах” гэснийг “баримтад тооцохгүй” гэж, 115 дугаар зүйлийн 115.4 дэх хэсгийн “шүүгчид” гэснийг “гишүүнд” гэж, төслийн “шүүгч биш гишүүн” гэснийг “шүүгч бус гишүүн” гэж тохиолдол бүрд өөрчлөх.

3.Төслийн 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсгийн “ажиллах” гэснийг, 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалтын “өөрийн хүсэлтээр” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.7.3 дахь заалт, 34.12 дахь хэсгийн “хөндлөнгийн” гэснийг, 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсгийн “сургалтад суух” гэснийг, 45 дугаар зүйлийн 45.8 дахь хэсгийн “бүхий л” гэснийг, 73 дугаар зүйлийн 73.1.1 дэх заалтын “хангалтыг зохион байгуулах,” гэснийг, 74 дүгээр зүйлийн 74.1.1 дэх заалтын “тодорхой” гэснийг, 75 дугаар зүйлийн 75.2 дахь хэсгийн “байнгын болон нүүдэллэн ажиллах” гэснийг, 84 дүгээр зүйлийн 84.1.3 дахь заалтын “болон өөр ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

Нэг.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн “олгохгүй.” гэж,” гэсний дараа “119 дүгээр зүйлийн 119.3 дахь хэсэг, 167 дугаар зүйлийн 167.4 дэх хэсгийн “7” гэснийг “14” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн ““Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 59.1.5-т заасан үндэслэлээр огцруулсан, 59.6-д заасны дагуу огцорсонд тооцсон,” гэснийг “шүүгч Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан огцруулах сахилгын шийтгэл хүлээсэн, эсхүл огцорсонд тооцогдсон,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гурав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “тайлбар” гэснийг “мэдүүлэг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 92,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дөрөв.Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

1.Төслийн 7 дугаар зүйлийн “томилогдсон” гэсний дараа “шүүгчийн бүрэн эрхийг энэ хууль хөндөхгүй бөгөөд” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 92,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/- ийн 46.2-т заасан нэмэгдлийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 12 дугаар зүйлийн “49.7 дахь” гэснийг “48.9 дэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төсөлд доор дурдсан агуулгатай 15 дугаар зүйл нэмэх:

“15 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болж дагаж мөрдөхөөс өмнө Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргасан хэрэг, маргаанд Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25.7.5 дахь заалт хамаарахгүй бөгөөд хэрэг, маргааныг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, энэхүү хуультай холбогдуулан баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө дагаж мөрдөж байсан хуулиар хянан шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 5. Төсөлд доор дурдсан, уучлаарай. 12 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 91,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай 16 дугаар зүйл нэмэх:

“16 дугаар зүйл.2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр баталсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23.2-т заасан бүх шатны шүүхийн шүүгчийн цалингийн нэмэгдэлтэй холбогдох заалтыг 2021 оны төсвийн жил дуусах хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 91,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа. Төслийн 9 дүгээр зүйлд 9.2 дахь заалт нэмэх. Энэ хуулийн 9.1-д заасныг зөрчсөн этгээд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ. Энэ нөгөө Үндсэн хууль зөрчсөн заалт уу, юу билээ өөр уу Пүрэвдорж гишүүн саналаа тайлбарлая.

Б.Пүрэвдорж: Энэ 9 дүгээр зүйлийн 9.1 дээр ингэж байгаа юм. 9 дүгээр зүйл дээр. Гарчиг нь бол гэм буруутайд тооцож үл болох. 9.1 гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно гэж байгаа юм. Энэний 9.2 дээр энэ хуулийг зөрчсөн бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ гэж байгаа юм. Тэгэхээр энэ хамгийн хойд тал дээр энэ 118.1, 118.2

дээр бол энэ хуулийг зөрчсөн гээд энэ эшлэл байхгүйгээр явсан байж байгаа. Тэгэхээр ер нь бол энэ дээр би ямар зүйлийг хэлэх гээд байна вэ гэхээр ер нь бол хуулийн байгууллагынхан хэн нэгэн одоо шалгаж байгаа хүнийхээ гэмт хэргийг олон нийтэд задалдаг тэрнийгээ урьдчилж одоо нийгэмд тэр хүнийг буруутай мэт харагдуулах бүх зүйлийг хийчхээд тэрнийхээ дагуу шүүх хуулийн байгууллага тэр хүмүүсийг ялладаг. Өөрөөр хэлбэл яг тэр хүмүүсийн хамгийн эцсийн гэм буруутайд тооцох тэр шийдвэрийг гаргаж хүмүүс нь шүүгч нар байгаа.

Тийм учраас яг энэ хууль дээр энэ заалт дээр нь яг тодорхойлж энэ эшлэлийнх нь дагуу оруулъя гэсэн ийм саналыг л гаргаж байгаа юм. Ер нь бол сүүлийн үеийн нөхцөл байдлаас харахад бол энэ хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээрээс нь энэ сошиал ертөнцөөр энэ тухайн хүнийг гэм буруутайг нь буруутай мэтээр одоо шүүхээр шийдээгүй байж байхад асуудлыг нь гаргаж тавьдаг ийм зүйл хэрээс хэтрээд байгаа. Тийм учраас шүүгч нарыг бас тодорхой хэмжээгээр хариуцлагажуулах хуулийн байгууллагын албан хаагч нарыг тодорхой яг энэ заалтаар нь хариуцлага тооцох энэ эшлэлийнх нь дагуу боломж гаргахын тулд л энийг санал хураалгаж байгаа юм.

С.Бямбацогт: Пүрэвдорж гишүүний гаргаж байгаа санал бол бас яригдсан. Ер нь бол бас цаашид бол илүү анхаарах ёстой санал. Өнөөдөр бол яг нийгэмд тийм гаж үзэгдэл тогтоод байгаа. Тэгээд шүүхээр хэн нэгэн гэм буруутай нь тогтоогдоогүй байхад тэгээд л гэмт хэрэгт холбоод л гүтгээд л гутаагаад доромжлоод л тэгээд хэвлэл мэдээллээр сэвээд л яах аргагүй одоо юу гэдэг юм гэмт хэрэгтэн болгохоос өөр аргагүй байдалд мөрдөгч прокурор одоо шүүх гээд дамнаад дамнаад ийм асуудал бас үүсдэг юм байдаг. Тэгэхээр үүнтэй холбоотой энэ хуульд бол заалт орсон Пүрэвдорж гишүүнээ. Тэр 9 дүгээр зүйл дээр гэмт буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно гээд орсон. Яг үүнтэй холбоотойгоор хуулийн 118 дээр тийм үү энэ хуулийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хуулийн хариуцлага хүлээлгэнэ гээд орсон. Өөрөөр хэлэх юм бол одоо ийм асуудал үүсэх юм бол таны ярьж байгаа асуудал үүсэх юм бол эрүүгийн хуулийн хариуцлага хүлээдэг байхаар орж ирж байгаа. Тийм болохоор таны энэ санал тусгагдсан учраас дахиж санал хураах боломжгүй байна. Энийг та бас ойлгоорой. Дэгийн хуулиар ч гэсэн бас зөрчил болох гээд байгаа учраас. Ер нь бол энэ хөндөж байгаа асуудал чинь бол зарчмын хувьд зөв асуудал. Орсон учраас санал хураалгах бололцоогүй. Протоколд бол тэмдэглэл үлдээе.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр гишүүн танилцуулна. Дэгийн тухай хууль уу?

Дөрөв.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал бана уу? Байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал хураалт байна уу? Бичгээр гаргасан санал байхгүй байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан, анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Горимын санал Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Баярлалаа. Энэ Их Хурлын Шүүхийн тухай хуулийн анхдугаар хэлэлцүүлэг чуулганаар явагдахад Улсын Их Хурлын даргаас чиглэл өгсний дагуу нөгөө Шүүхийн тухай хуульд байгаа Улсын Их Хурал дээр явагдах процессууд буюу шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүдийг томилох, сахилгын хорооны шүүгч биш гишүүдийг Улсын Их Хурлаас томилох мөн улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчдээ Улсын Их Хурал нөгөө танилцах процессуудыг техникийн хувьд Дэгийн хуульдаа бич. Шүүхийн хуулиасаа зөөгөөд Дэгийн хууль руугаа оруул гэдэг тэр чиглэлийн дагуу дэгийн хууль руугаа оруулж байгаа энэ техникийн өөрчлөлт юм.

Тийм учраас ээн асуудлыг бол бид зарчмын хувьд нь бол анхдугаар хэлэлцүүлгээрээ шийдсэн хэлэлцсэн. Тийм учраас Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр нь батлах ийм горимын саналыг дэмжиж өгөөч гэсэн саналыг гаргаж байна.

С.Бямбацогт: Энхбаяр гишүүн горимын санал гаргаж байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй бол хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно гэж заасан байгаа. Үүний дагуу сая саналууд гараагүй Энхбаяр гишүүн анхны хэлэлцүүлгээр нь нэгтгээд баталъя гэсэн горимын санал гаргаж байна. Тийм учраас Энхбаяр гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Энхбаяр гишүүний горимын санал дэмжигдлээ. 11 гишүүн буюу 91,7 хувийн саналаар дэмжигдлээ. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн гишүүдээр уншуулъя.

Сүхбаатар гишүүн, Алтанхуяг гишүүн гээд энэ хүмүүсээр. Сүхбаатар гишүүн танилцуулъя.

Тав.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан санал байна уу? Байхгүй байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна. Горимын санал Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Баярлалаа. Энэ яг түрүүний хэлсэн үндэслэлтэй адилхан. Өөрөөр хэлбэл нөгөө Улсын дээд шүүхийн шүүхэд нэр дэвшигчийг Улсын Их Хурал танилцана гэж байгаа тэрийг нөгөө танилцах сонсгол хийе гээд анхны хэлэлцүүлгээр чуулганаар дэмжсэн. Гэхдээ техникийн хувьд Нийтийн сонсголынхоо хуульд нэмэлт өөрчлөлт оруул гэдэг чиглэлийг Улсын Их хурлын даргаас өгсөн байгаа. Тэр чиглэлийн дагуу Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцэж байгаа. Тийм учраас энэ нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь баталж өгөөч ийм горимын санал гаргаж байна.

С.Бямбацогт: Дэгийн тухай хуулийн 39.22-д заасны дагуу сая гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын санал Энхбаяр гишүүн гаргаж байна. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг гишүүн Норовын Алтанхуяг гишүүн танилцуулна.

Зургаа.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай болон Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулттай гишүүд байна уу? Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн. Сэргэлэн гишүүн асуултаа асууя.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Энэ шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай гэсэн тогтоолын хоёрдугаарт шүүгчид олгох докторын зэргийн нэмэгдлийг шүүгчийн албан тушаалын үндсэн цалингийн арван хувиар тогтоосугай гэсэн ийм заалт байгаа юм. Тэгээд би энийг энэтэй холбогдуулж л асуулт асуух гэсэн юм. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны гурван зуун 382 тогтоолын гуравдугаар хавсралтаар төрийн албан хаагчдад докторын зэрэг профессор цолны нэмэгдэл олгох журам батлагдсан. Одоо төрийн албан хаагчдад яг энэ журмын дагуу зэргийн нэмэгдэл олгоод явж байгаа. Энэ доктор профессорын. Жишээлбэл, шинжлэх ухааны докторын зэрэг гэвэл албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь нь хорин хувь гээд заачихсан байгаа юм. Гэтэл энэ Улсын Их Хурлын тогтоолоор арван хувь гээд ороод ирж байгаа юм. Тэгээд энэ эрх зүйн талаасаа хоёрдугаарт энэ чинь шүүгчдийн нийгмийн баталгаа талаасаа улам дордуулсан заалт Засгийн газрын тогтоолоос доошоо ороод ирэх юм. Тэгээд энэ талаас нь ха энэ засгийн газрын тогтоолыг харж үзсэн юм байгаа юм уу. 2018 оны 382 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт шүү Засгийн газрын.

Тэгэхлээр би бол энийг ингэж харж байна. Зүгээр нэгдүгээрт асууж байгаа юм. Энийг одоо та ажлын хэсэг маань анзаараагүй ч байж болно л доо. Тийм учраас энийг энэ Засгийн газрын тогтоолоос ядаж бууруулахгүй байх нь зүйтэй юм болов уу гэсэн ийм би санал хэлж байгаа юм. Асуулт асуухын хажуугаар. Тэгэхлээр энэ дээр одоо зарчмын зөрүүтэй санал гаргаад нэмж болдог бол тийм санал гаргаад хорин хувь гэвэл ядаж хорин хувь байх нь зөв байх л гэж би бодож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Яагаад арван хувь гээд биччихсэн хорин хувь байх ёстой гээд яриад байна шүү дээ. Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Сэргэлэн гишүүний асуултад хариулъя. Үгүй ээ энэ чуулганы л хурал дээр л одоо энэ шүүгчдийг л одоо юм нэмэх гээд байна гээд л айлгачих юм байна шүү дээ. Одоо ерөөсөө тэгээд хамгийн даруухан дээрээ тавьчихсан одоо энэ чинь. Тэгээд л оруулж ирж байгаа, тэгээд Сэргэлэн гишүүний одоо зарчмын байр суурийг бол одоо дэмжиж байна. Баярлалаа. Ер нь их олон тийм доктор шүүгч нар бол байхгүй. Чадвартай мэргэжилтэй, мэргэшсэн ийм, одоо хуульчид шүүгч бас байгаасай, ажиллаасай гэдэг утгаар бол одоо таны саяын саналыг бол талархан дэмжиж хүлээж авч байна. Та санал гаргачихвал дэмжихэд бэлэн байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьяа: Би энэ шүүгчид олгох докторын зэргийн нэмэгдлийн тухай бас байр сууриа илэрхийлье гэж бодсон юм. За энд бол Засгийн газар хорин хувь олгодог. Энд хуулийн тогтоолын төсөл дээр арван хувь гээд энэ асуудлыг яриад байна л даа. Тэгэхлээр одоо энэ өнөөдөр ажиллаж байгаа таван зуу гаруй шүүгчдээс ерөөсөө тав, зургаан л хүн докторын тийм зэрэгтэй юм байна лээ шүү дээ. Тэгэхлээр бол энэ докторын зэрэг гэдэг юмыг энд оруулахгүйгээр, тэр шүүгчийн шүүн таслах ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 35, 40 болгоод оруулчихвал ер нь олонхын одоо эрх ашгийг хамгаалсан ийм заалт болох байх л гэж би бодож байна. Ийм санал би дэвшүүлж байгаа юм, тийм. Үгүй ер нь энэнийг нь яагаад тэр гучин тэгээд докторыг нь хасчихвал яадаг юм гэж бодож байгаа. Таван хүн байна шүү дээ.

С.Бямбацогт: Энх-Амгалан гишүүн асуулт асууя. Шүүхийн тухай хууль ингээд хоёрдугаар хэлэлцүүлэг нь явж байна. Бид нар энэ хуулийг хийхдээ нэг л зүйлийг анхаарсан. Тэр нь юу вэ гэхээр зэрэг Монгол Улсын бүх иргэд шударга шүүхээр шүүлгэнэ л гэж ингэж анхаарсан. Түүнээс шүүгчийнхээ энэ халдашгүй байдал, шүүхийн хүний нөөцөөр хангах тухай асуудал, шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал, шүүхийн санхүү эдийн засгийн баталгааг хангах тухай асуудал, шүүгчдийн нийгмийн баталгаа хангах тухай асуудал дээр бол ямар нэгэн байдлаар одоо энэ дээр нь хасах танах зүйл байж болохгүй. Ингэж л бодож байгаа юм. Яагаад гэхээр эд нар маань одоо ингээд бизнес эрхэлж болохгүй, хууль зүйн зөвлөгөө өгч болохгүй. Энд тэнд очиж одоо ингэж одоо хийж байгаа ажлынхаа талаар ямар нэгэн одоо мэдээлэл хийж болохгүй. Ингээд хуулиар эрхүүд нь хязгаарлагдчихсан. Тэр битгий хэл төрийн одон медаль, шагнал ч авч болохгүй болчихсон. Ийм нөхцөлд энэ шүүгчдийнхээ одоо нийгмийн баталгаа, амьдралын баталгааг хангах асуудал дээр бол хуучин өргөн мэдүүлж байсан бид нар нэг арван хэдэн заалт, анхны хэлэлцүүлгээр нэг хураагаад байсан шүү дээ. Яг ийм ийм юмнууд байна. Гучин зургаан сарынх нь юмнууд байна гээд тэд нар яг бүгд үлдэх ёстой юм.

Миний оруулсан ганцхан санал юу юм бэ гэхээр зэрэг шүүгч өвдөх юм бол бүх зардлыг нь улсаас даадгийг л болиулчихъя гэсэн байхгүй юу. Түүнээс бусад юмыг нь бол ерөөсөө хасаагүй шүү дээ. Тэр одоо албан тушаалаасаа болоод гэмтсэн, өвдсөн эрүүл мэнд нь хохирсон бол бүгд л орох ёстой. Зөвхөн шүүгч зүгээр эрүүл мэндийнх нь байдал муудахаар улсаас даадаг нь л орхисон болохоос биш бусад нь яг тэр чигээрээ байх ёстой шүү гэдэг би урьдынхаа байр суурин дээр хэвээрээ байгаа. Шүүгчдийн цалин мөнгийг хасах, тэр нэмэгдлийг нь бууруулах, тэр докторын зэргийг нь хасах ийм, ийм юм байж болохгүй. Тэр гучин зургаан сар нь бүгд байна. Энэ хүмүүс чинь энэнээс өөр орлого байхгүй шүү дээ. Улсын өмнө тангараг өргөчихсөн учраас. Тэгэхээр миний байр суурь бол бол яг энэ шүүгчдийн нэмэгдлийн асуудал дээр бол өмнө нь байсан байр суурин дээрээ байна. Энийг яг энэ чигээр нь явуулах нь зөв зүйтэй л гэж ингэж үзэж байгаа юм.

С.Бямбацогт: Дэмжиж байна, санал уу? Санал байсан. Ганбат гишүүн.

Д.Ганбат: Би арай өөр байр суурьтай байгаа юм. Яг ингээд логигоороо харьцуулаад ингээд үзэхээр чинь юу шүү дээ. Доктор үнэхээр энэ шүүгчийн хийж байгаа ажил энэ завгүй, ачаалалтай энэ нөхцөл байдал энэ тэрийг нь дүгнээд үзэхээр бол яг докторын диссертац хийгээд л, хамгаалаад л байх тийм зав чөлөө баймааргүй байгаа юм. Одоо нэг таван доктортой л байгаа юм байна. Тэр нь болохоор мэдээж хэрэг өмнөх нөхцөл байдалд орж ирээд доктор болчихсон хүмүүс байгаа байх. Тэгэхээр тэр одон медалийг нь гарсан юм чинь яг тэрэнтэйгээ адилхан, энэ докторын зэрэг гээд онцгойлж авч үзээд ингэмээргүй байна. Олон нийт, Монголын нийгэм бол бүгдээрээ л шударга шүүхийг хүсэж байгаа. Тэр шүүх маань хөгжингүй орны стандартад очтол их зайтай байгаа. Гэхдээ энэ шүүхийн тухай багц хуулиар бол бас нэг ч гэсэн алхам урагшилж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ дотор нь бас ялгаварлаад шүүгч нарыг докторын зэрэгтэй энэ тэр гэж ялгаж салгаж байхаар нөгөө шүүгч нарынхаа цалинг арай дээр болох тэр тал руугаа л явсан нь дээр байх. Хараат бус байдал, шүүгчийн хараат бус байдлыг аль болохоор бий болгохын тулд ингэх энэ чиглэл рүү л явсан нь дээр. Тэгээд одоо хэдэн шүүгч, доктор байгаа юм. Ямар шуухан докторууд байдаг юм. Энийг нэг тодруулаад өгчих үү?

С.Бямбацогт: Хэн ажлын хэсэг хариулаад байх уу? За 3 номер Баасандорж дарга дараа нь бас бэлдэж байгаа ажлын хэсэг.

Б.Баасандорж: Докторын нэмэгдэлтэй холбоотой асуудлыг Мөнхсайхан доктор хариулах байх. Би зүгээр энэ тогтоолын төсөлтэй холбоотой хуралдаанд оролцоод зөвшөөрвөл нэг санал хэлэх гэсэн юм. Тийм энэ шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай тогтоолын төсөл байгаа. Тэгээд энэ хоёр хавсралттай байгаа нэг нь онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам, хоёр дахь нь төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл гээд. Тэгээд нийтлэг үндэслэлээрээ Төрийн албаны тухай хуулийн тавин долоогийн хоёрын гурвыг үндэслэсэн байгаа. Хэрэв бид энийг яах юм бол, энийг бол барьж болохгүй. Яагаад гэвэл Засгийн газраас оруулж ирсэн төсөл дээр тавин долоогийн хоёрын гурвыг үндэслэсэн юм. Тэгээд ажлын хэсгээс энийг больё гэсэн юм. Би зүгээр Байнгын хорооны гишүүдтэй нэг зүйлийг хэлэхэд шүүгч бол төрийн албан хаагч мөн мөн үү гэвэл мөн. Яг Төрийн албаны тухай хууль дөрөв ангилдаг төрийн албан хаагчийг улс төрийн, төрийн захирах, захиргааны үйлчилгээний гэсэн дөрвөн ангилдаг.

Тэгээд энэ Төрийн албаны тухай хууль арван есөн оны нэг сарын нэгнээс хэрэгжиж эхэлсэн. Энэ тавин долоогийн зургаа дээр, хэрэв шүүгчийн нэмэгдлийн хэмжээг яривал санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн албаны зөвлөлөөс заавал санал аваарай гэж байгаа. Тавин долоогийн хоёрын гурав дээр, тавин долоогийн хоёрын гурав дээр төрийн тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны зэрэг дэвийн болон зэрэг нэмэгдлээс бүрдэнэ гээд. Тэгэхээр эндээс би зүгээр протоколд хэлэхэд энэ зэрэг дэвийн нэмэгдэл бол төрийн албан хаагчийн хувьд бол заавал байх ёстой нэмэгдэл шүү. Тэгэхээр энэ тогтоолоор зэрэг дэвийн нэмэгдэл өөрөө байхгүй болж байгаа нь энэ арван есөн оны нэг сарын нэгнээс хэрэгжсэн Төрийн албаны хуультай зөрчилдөхөөр харагдаж байгаа шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

С.Бямбацогт: 2 хариулах уу, шүүхийн ерөнхий зөвлөл хариулах уу, бас сая хариулъя гэсэн үү тийм ээ? За Атарцэцэг гишүүн шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн.

Л.Атарцэцэг: Өмнөх Ганбат гишүүний асуултад одоо манай таван зуун арван найман шүүгч дотор улсын дээд шүүхэд нийт гурван доктор байдаг юм. Анхан шатны шүүхүүдэд нийт гурван зуун наян найман давж заалдах шатны шүүхийн 107, 400 гаруй шүүгч нар дотор гурван доктор. Ингээд нийтдээ нэг зургаан доктор байгаа. Тэгэхээр бол зүгээр яг докторынхоо нэмэгдлийн тухайд бол бид нар тэр Сэргэлэн гишүүний хэлсэн саналыг бол дэмжиж байна. Яагаад гэвэл бид нар Засгийн газрын тогтоолдоо нийцүүлээд, тэрийг бол тийм. Зүгээр ажлынхаа хажуугаар докторын зэрэг хамгаалаад байх боломжийн тухайд бол өөрийгөө хөгжүүлж одоо энэ түвшинд хүрснийхээ төлөө авах нэмэгдлийг бол бид нар мэдээж хязгаарлаж болохгүй. Дараагийн асуудал юу, байлаа? Үгүй ээ, би бол одоо зүгээр, юун тэр.../үг тасрав/

С.Бямбацогт: Хариулт болчихсон уу? Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй саналууд ажлын хэсгийн саналаас гадна бас гишүүдээс санал гарсан байна. Энэ чинь одоо аль алианаар нь санал хураалгах уу? Энэ чинь нөгөө тогтоолын төслийн хавсралтын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам ажлын хэсэг

бол дөчин хувь гэж бид нар тогтсон. Тэгээд ажлын хэсгээс орж ирэх санал дөчин хувь л нэмэгдлийг олгоно гэж орж ирж байгаа. Тийм ээ. Ганбат гишүүн маань дөчин таван хувиар олгоё гэсэн санал гаргаж байна. Тэгээд одоо Ганбат гишүүний саналаар санал хураалгах уу? Хэрэв санал байхгүй бол ажлын хэсэг санал дэмжигдсэн гээд явчих гээд байгаа байхгүй юу. Дөч сая бид нар нэлээн ярьсан шүү дээ. Тийм ээ, тийм. Ганбат гишүүний дөчин юу санал дэмжигдэхгүй бол ажлын хэсгийн санал дэмжигдээд дөчин хувиар явна гэсэн үг дээ. Ганбат гишүүлэн санал хэлье.

Д.Ганбат: За яах вэ, ерөнхийдөө энэ Хууль зүйн байнгын хороо хуралдаж байна. Яг бүрэн утгаараа энэ дээр л яг энэ шүүхийг хараат бус байлгах, тэр нөхцөл байдлыг нь бий болгохын тулд тэр ойлгомжтой тайлбарыг нь хэлээд ойлгомжтой санал хураалтыг нь явуулаад ингэх ёстой. Тэгэхгүй бол чуулган дээр бол бас попууд гарч ирж байна шүү дээ. Тэгээд энэ хийсэн ажил маань юу ч биш болчих гээд байна шүү дээ. Тэрийг та бүхэн ойлгоорой. Нөгөө талаар бол шүүгч гэдэг маань ямар олон эрхээ хасуулж байна тийм ээ хувь хүнийхээ хувьд. Тэрэн дээр бас ойлголтыг нь одоо голдиролд нь оруулаад зөв зүйтэй тайлбарлаад ингэх цаг нь болсон. Өнөөдрийн Байнгын хорооны хурлаас энэ юм ингээд яригдаад явж байна. Түрүүн ажлын хэсэг бол тэгнэ ингэнэ гээд баахан айдастайгаар нэг гучин таван хувьтай оруулж ирсэн юм шиг байна. Энэ Хууль зүйн байнгын хороон дээр яриад зөв ойлголт аваад дөч болгож байна.

Тэгээд яг би энэ дөчин хувь гаргасан энэ юмыг чинь бас харлаа үзлээ. Тэгээд ингэсэн чинь яг хуучин орж байсан гар дээр нь ирж байгаа цалин мөнгөөрөө бол зарим нь багасчхаж байна. Тэгээд энэ онцгой байдлын нэмэгдэл гэдгээрээ Авлигатай тэмцэх газрын албан хаагчид бол дөчин хувийг авдаг юм байна. Гэтэл нөгөө тулгийн чулуу болсон шүүхийн хараат бус байдлыг бий болгох, олон түмэндээ шударга үйлчилгээ үзүүлэх энэ шүүгч шүүгч нар маань Авлигатай тэмцэх газрын хэмжээнд л ингэж байх байх шиг байна. Тэгэхээр тэрнээс арай нэмүүлээд дөчин таван хувь болгочихвол энэ ажил маань зөв зүйтэй болоод явчих юм байна гэж энэ зарчмын зөрүүтэй саналыг гаргасан юм. Хууль зүйн байнгын хороо энийг дэмжээд явчих нь зөв байх. Тэгээд чуулган дээр энийгээ сайн тайлбарыг нь хэлээд бас нэг ч гэсэн зөв зүйтэй юм хийе хэдүүлээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ганбат гишүүнээ ерөнхийдөө бид нар сая ажлын хэсгийн оруулж санал дээр нэлээн сайн өглөө яриад тогтчихсон шүү дээ. Заавал одоо санал гаргаад байх юм. Ингээд явчхаж болохгүй юм уу? Шүүхийн ерөнхий зөвлөл Атарцэцэг. Шүүхийн энэ зөвлөл манай шүүхийн боловсон хүчин, хараат бус байдал хариуцдаг. Нэгдүгээр микрофон.

Л.Атарцэцэг: Ер нь бол зүгээр бид нар анхнаасаа шүүхийн ерөнхий зөвлөл бол ямар байр суурьтай явсан гэхээр нөгөө энэ засгийн үндсэн төсөл маань бид нарт одоо ингээд багцаар нь тоогоо хэлэх юм бол энэ чинь нийтдээ нөгөө нэг зэрэг дэвийнхээ нэмэгдлийг оруулаад дөчин таваас далан таван хувийн нэмэгдэл, нөгөө нэмэгдлийнхээ тоог. Би тэр нь одоо нөгөө онцгой ажлын нэмэгдэл, төрийн албаны нэгдэл зэрэг дэвийн нэмэгдлийг ингээд таваас арван тав, хорин таваас гучин тав гэдэг дээд нэмэгдлийнх нь хэмжээ далан тав, одоо хуучин төслөөр явах юм бол. Энэ маань ингээд нөгөө ажилласан жилээсээ хамааралтай, мэдээж өсөөд явчихна. Дараагийн одоо энэ бид нарын энэ томьёоллоор бид нар дөч гэдгийг хамгийн одоо ажлын хэсгээс санал болгосон хамгийн их юугаар нь бодоод үзээч гээд ингэхээр шүүгчдийн маань нэмэгдэл

дөчин таваас жаран таван хувь буюу анхныхаа одоогийн гар дээр авч байгаа засгийн гар дээр авч байгаа цалингаас буурахаас гадна засгийн төслөөс бол нэг арван хувийн зөрүү гарна. Энэ дээр бид нар одоо дэмжээд яах вэ одоо дөчөөр нь байж болох юм гээд ингээд ажлын хэсэг дээр олноороо яриад ингээд шийдсэний дагуу ингээд бодохоор юу гараад байна гэхээр би түрүүн үгүй ээ яах вэ, би зүгээр тэрэнд нөхцөл байдлыг би хэлж байж одоо санал хураахад бас нэг бодитой тоо гаргаасай гэдгээрээ яриад байгаа юм.

Ингээд нэмэхээр юу болоод байна гэхээр нөгөө олон жил ажилласан, хорин нэгээс дээш жил ажилласан улсуудын маань цалин буурч эхэлж байгаа юм. Энэ дээр бол шүүгч нар бас их эмзэг хандаж байгаа. Тэгэхээр одоо бид нар бол энэ буурч байгаа улсуудын одоо зөрүү тэд нар яаж тайлбарлах юм, одоо шүүгчдийн цалингийн хэмжээ буурч болохгүй гэсэн үндсэн одоо нэг зарчмаасаа бол бид нар дөчин хувь болгосноороо нөгөө хоёр хувийгаа хассанаараа ийм л нөхцөл байдал үүсээд байгаа юм. Гэхдээ бид нар одоо түрүүн тайлбарласан их хурлын одоо эрхэм гишүүд маань саналаа хураалгахдаа. Одоо яг нөхцөл байдал нь бол Засгийн төсөл нь ийм байна. Дөчин хувийн төсөл нь ийм байна. Тэгээд бид нарын одоо шүүгчдийн цалингийн хэмжээг бууруулахгүй байх тал дээр нь бас ярьж өгөөч гэдэг л ийм л юмыг бид нар хэлж хүсээд байгаа юм л даа.

Засгийн төслөөр ингээд орох юм бол Засгийн төслөөр орох юм бол бид нар одоо нөгөө Төрийн албаны тухай хуулийн тавин долоодугаар зүйлийн тавин долоогийн хоёрын гурав гэдэг томъёоллоо оруулаад дээр нь шүүгчид зэрэг дэвтэй байна гэдгээ оруулаад тэгээд одоогийн энэ нөгөө нэг төслөө хийхдээ бид нар одоогийн онцгой ажлын нэмэгдэл арван таван хувиар, төрийн албаны нэгдэл нэмэгдэл таваас хорин таван хувиар, зэрэг дэвийн нэмэгдэл хамгийн өндөр нь буюу хорин таваас гучин таван хувиар тооцогдоод байгаа юм. Ингээд энэ Засгийн төслийн доод хувийг нь дээд хувьтай нь харахаар дөчин таваас далан таван хувийн нэмэгдэл гарч байгаа энэ нөгөө ажилласан жилээсээ хамаараад ингээд явчихна.

С.Бямбацогт: Ер нь байна шүү дээ бид нар одоо Атарцэцэг зөвлөлийн шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээ онцгой нөхцөлийн нэмэгдэл одоо авахгүй байгаа. Төрийн албан хаагчийн нэмэгдэл одоо авахгүй байгаа. Шүүгч нар тийм биз? Авахгүй байгаа. Авахгүй байгаа юм чинь Засгийн газар өгье гэж оруулж ирсэн хуулийн төсөл дээр. Ажлын хэсэг, Байнгын хороо дэмжээд явуулсан чуулган дээр очоод уначихсан. Сая дахиад ярьж байгаад бид нар ингээд дөчин хувийн нэмэгдэл байж болох юм гэж ойлголцоод огт алга болчихсон юмыг чинь тийм үү чуулган дээр алга болчихсон юм чинь буцаагаад оруулъя гэхээр энэ чинь бага байна, одоо авч байсан юм буурчих гээд байна гээд шал эсрэг яриад байх юм. Бүр мушгиад одоо энэ чинь тийм. Нөгөө чамлахаар чанга атга гээд энэ чинь ороод ирж байгаа юм чинь болж байгаа юм биш үү дээ. Уул нь өглөө ярьчихсан шүү дээ. Тийм. Одоо ингээд л байх юм энэ чинь унана шүү дээ тэгээд. Авахгүй хэзээ ч авдаггүй юмыг бид нар авдаг болгоод орж ирж байна шүү дээ. Засгийн газар өргөн барьсан нь уначихсан байсан бид нар Хууль зүйн байнгын хороо ярьж байгаад эргүүлээд оруулж ирж байна шүү дээ. Онцгой нөхцөлийн юмыг л төрийн албан хаагчийн ажилласан хугацааны нэмэгдэл гээд огт авдаггүй байсан шүү дээ. Одоо анх удаа авах гээд байна шүү дээ. Дэмжихгүй байхад нь бид нар дэмжээд явуулчихсан шүү дээ.

Тэгж байхад нь авдаг юмнууд нь хасагдчихсан. Одоо бүр дахиад нэмчихмээр байна гээд ингээд байх юм. Ганбат гишүүнээ та бас нэг жоохон бас яая л даа. Одоо энэ чинь бүр хэсгээрээ уначихсан чуулган дээр уначихсан шүү дээ. Бид нар уначихсан юмыг бид нар бас, хураагаад уначихсан. Ганбат гишүүн.

Д.Ганбат: Үгүй ээ, үгүй бид нар чинь ийм шүү дээ. Энэ хуулийнхаа зүйл заалтыг хар л даа. Энэ чинь одоо нөгөө шүүгчийн авч байгаа цалинг дордуулж болохгүй шүү дээ. Өмнө нь байснаасаа. Тэгэхээр дордох болчихоод байгаа байхгүй юу. Тэр баахан доктор энэ тэр бол хэнд хамаатай юм. Хэнд ч хамаагүй шүү дээ. Бид нар одоо шүүхийн шүүгчийн хараат бус байдлыг л сайжруулах гээд байна. Энэ хуулийн чинь утга учир нь шүүгч шүү дээ. Шүүгчээ хараат бус байлгахгүй л юм бол энэ яриад байгаа юм чинь зүгээр цаасан дээр л үлдэнэ шүү дээ. Тэгээд ярихдаа та нар одоо бас тийм, ийм гээд ямар ч судалгаагүйгээр нэг унах ёстой, унагах ёстой гээд тиймэрхүү юм яриад байх юм. Тэгж болохгүй шүү дээ. Тэр тусмаа энэ Хууль зүйн байнгын хороон дээр мэргэжлийн хуульч нар. Энийг одоо нийгэм ойлготлоо бол нэлээн удна. Энэ чинь одоо энэ шударга шүүхтэй болох гээд л гучин жил зүтгэж байна. Тэгээд тэрийг одоо энэ хүмүүс чинь чөлөөт цагаараа багш нар шиг хичээл зааж болохгүй, эмч нар шиг хувийн эмнэлэгтээ очоод ажиллаж болохгүй ийм л улсууд шүү дээ.

Тэгээд сая хэлж байна, тэр шүүхийн ерөнхий зөвлөл нь дөчин таваас жаран таван хувь байж хэвийн хэмжээндээ очно гэж байна. Тэрний хамгийн бага дээр нь тавьж байна шүү дээ. Дөчин тав гээд. Ийм судалгаатай юм яриад байхад л цээжнийхээ юугаар л юм яриад байх юм. Тэгж болохгүй ээ, ингээд унана барина гээд. Үгүй ээ, би одоо ерөөсөө энэ шударга шүүхтэй болохын төлөө л зүтгэж байна. Тэрний төлөө явж байна. Тэрнийхээ төлөө саналаа гаргалаа. Бүрэн эрхийнхээ хэмжээнд. Тэгээд та нар үгүй ээ, Бямбацогтоо чинь боль л доо, тэгвэл тэгнэ ингэнэ тийм ээ. Та нар ч одоо ийм байж болохгүй шүү дээ. Энэ одоо Байнгын хорооны хурал, чуулганы юу болох гээд байгаа юм бэ. Энэ чинь одоо тэгвэл тэгнэ, ингэвэл тэгнэ гэсэн тиймэрхүү, иймэрхүү маягаар байж болохгүй ээ. Тэр судалгаа дээр тооцоон дээр явж байгаа юмыг тэрэн дээр ярина уу гэхээс биш зүгээр нэг попорсон юмаар бол ярьж болмооргүй байна. Тэгээд л аль ч үгүй болно. Тийм болчихно, ийм болчихно гээд байх юм. Тэгвэл наад шүүхийнхээ хуулийг татаж ав л даа. Та нар Засгийн газраар нь татуулахгүй юу.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч, Ганбат гишүүнээ ийм байгаа шүү дээ. Та бас жаахан буруу ойлгоод байна. Та буруу ойлгоод байна, тийм. Энд чинь ингээд хавсралт байж байгаа. Төрийн албан хаагчийн ажилласан хугацааны нэмэгдэл, онцгой нөхцөлийн нэмэгдэл, тэр докторын нэмэгдэл, тэр зэрэг дэвийн нэмэгдэл гээд ийм нэмэгдлүүдийн нийлбэр нь дөчин таваас далан таван хувь байсан байхгүй юу Ганбат гишүүнээ. Түүн дотроо ганцхан тэр онцгой нөхцөлийн нэгдэл чинь ерөнхийдөө гуч хүртлээ байсан. Авлигатай тэмцэх газар дээр дөчин хувь байсан. Тэгээд хамгийн дээд дээр нь бид нар дөчин хувь байя гэж оруулж ирж байгаа юм. Тэгтэл та дөчин тав болгоод би оруулж ирнэ гээд ингээд. Та жоохон буруу яриад байна, бас тийм. Энэ чинь бүх нэмэгдлүүдийн нийлбэр нь далан тав хүртэл байсан юм. Тийм. Эсвэл тэгээд Засгийн газарт нь үлдээх үү. Энхбаяр гишүүн ажлын хэсгийн ахлагч.

Б.Энхбаяр: Баярлалаа. Энэ ажлын хэсгээс оруулж ирсэн онцгой нөхцөлийн нэмэгдлийг дөчин хувиар нь шийдчих нь зөв байх. Энэ нэг аль нь илүү шүүгчид хайртай, хайргүйн тухай асуудал биш. Энэ нөгөө яагаад вэ гэхээр яах вэ Атарцэцэг, шүүгчийн хэлж байгаа нэг болгоомжлол нь юу вэ гэхээр дөчин хувиар тогтоочихоор шүүгчдийн

цалин одоогийнхоос буурах гээд байгаа гэж ерөнхий бид нар ойлгож болохгүй. Одоо ажиллаж байгаа таван зуун арван хоёр шүүгчээс таван зуун дөрвөн шүүгчийн цалин нь буурахгүй. Сая хэлээд байна шүү дээ. Гучин хэдэн жил ажиллаж байгаа найман шүүгчийн л асуудал байгаа. Тэр нь зуун мянгаас хоёр зуун мянган төгрөгөөр буурах гээд байгаа л асуудал байхгүй юу. 45 гэчих юм бол 8 шүүгчийн цалинг бууруулахгүй гээд бид нар 512 шүүгчийнхээ бүр хөөсрүүлээд нэмэх гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр чинь бас зардал мөнгө гарна. Асуудал болно шүү дээ.

Тийм учраас 40 хувь дээрээ бол тогтоод шийдчих нь зөв байх. Харин тэр цалин буурах гээд 8 шүүгчийнхээ асуудлыг шаардлагатай гэж гишүүд дэмжих юм бол цалинг нь бууруулахгүй гээд дагаж мөрдөх журмын хуульдаа зарчмаар шийдчихвэл бид бас болно шүү дээ. Тэр яг 8 шүүгчийн асуудал л яригдаад байгаа юу 100-200 мянган төгрөгийн цалингийн зөрүүний асуудал яригдаад байгаа юм. Ийм л саналтай байна.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан саналаар санал хураалт явуулъя. Тэгээд энэ дэмжигдэх юм бол Ганбат гишүүний санал дэмжигдэхгүй гэсэн үг.

Шүүн таслах ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3 дахь заалт, Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасны дагуу шүүгчид шүүн таслах ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2.Шүүн таслах ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл нь шүүгчээс гагцхүү Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуульд захирагдан шүүн таслах эрх мэдлийг хэрэгжүүлэх, шүүгчийн хараат бус байдлын баталгааны нэг мөн.

Хоёр.Шүүн таслах ажлын онцгой нөхцөлийг нэмэгдлийн хэмжээ түүнийг олгох.

1.Шүүгчийн шүүн таслах ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг шүүгчийн авч байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар бодож сар бүр олгоно.

2.Шүүн таслах ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг бүх шатны шүүхийн шүүгчид шүүгчийн албан тушаалд ажиллаж байгаа хугацаанд нь олгоно. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Урд талд нь тогтоол нь байгаа шүү тийм. Дэмжье. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Ажлын хэсгийн санал дэмжигдсэн учраас Ганбат гишүүний санал санал хураах боломжгүй.

Дараагийн санал хураалт. Энэ дахиад санал байгаа шүү дээ бас. 20 хувь гэж өөрчлөх гээд байгаа шүү дээ энэ. Пүрэвдорж гишүүн, Сэргэлэн гишүүний. Энийг эхнээс нь уншаад би яая. 20 хувиар нь уншаад явъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай.

1.Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн заалт, Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэг, Монгол Улсын Их

Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.“Шүүгчийн шүүн таслах ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл, олгох журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Шүүгчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, олгох журам”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2.Шүүгчид олгох докторын зэргийн нэмэгдлийг шүүгчийн албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар гэж бичих үү, эсхүл Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын хавсралт гэж бичих үү. 20 гээд явъя. Ажлын хэсгийн ахлагчийн саналаар цалингийн 20 хувиар тогтоосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын 1996 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 57 дугаар тогтоол, “Шүүгчид зэрэг дэв олгох тухай” Улсын Их Хурлын 2006 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 53 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Шүүгчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3 дахь заалт, Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасны дагуу шүүгчид шүүн таслах ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2.Шүүгчид олгох төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл нь шүүгчийн хараат бус байдлыг хангах баталгааны нэг мөн.

Хоёр.Шүүгчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ түүнийг олгох.

1.Шүүгчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн шүүгчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан албан тушаалын сарын цалингаас доор дурдсан хувиар олгоно:

Төрийн албан хаасан хугацаа /жилээр/	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ /хувиар/
5-10	5
11-15	10
16-20	15
21-25	20
26 ба түүнээс дээш	25

Нэмэгдлийг бас олгох нь.

2.Шүүгчийн төрийн алба хаасан хугацааг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дахь заалтад заасны дагуу тооцно.

3.Төрийн алба хаасан хугацааг шүүхийн Тамгын газраас тодорхойлж, шүүгчид олгох төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хувийг Шүүхийн ерөнхий зөвлөл тогтооно.

4.Төрийн алба хаасан хугацааг тогтоох үндсэн баримт нь нийгмийн даатгалын дэвтэр болно.

5.Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг бүх шатны шүүхийн шүүгчид олгоно. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Оруулсан ярьсан биз дээ түрүүн. Тусад нь ярьсан. Ганбат гишүүний саналтай холбогдуулаад. Дэмжье. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай болон Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Адьшаа гишүүн танилцуулъя. Ажлын хэсгийн гишүүн. Редакц байна уу, 3 дугаар микрофон ажлын хэсэг. Баасандорж.

Б.Баасандорж: Хуралдаан даргалагчид баярлалаа. Хууль зүй дотоод хэргийн яам Баасандорж. Сая Байнгын хорооны гишүүд шүүгчид журам батлах тухай тогтоолын төслийг дэмжлээ. Энэ дэмжсэнтэй холбоотойгоор ажлын хэсэг дээр Байнгын хороон дээр шүүхийн тухай хууль дээр энэ Төрийн албаны тухай хуулийн 57.2.3-г үндэслэл болгохгүй. Энэ 2.3-аар явахгүй гэж нэгэнт шийдсэн. 2-т АТГ-ын нэмэгдлийн хэмжээг бол яг Авлигын эсрэг хуулиа л үндэслэдэг. Энэ 57.2.3 бол зүгээр шүүгчийн цалин хөлс нь ийм зүйлээс бүрдэнэ шүү гэсэн заалт. Тэгэхээр энэ үндэслэх тогтоох хэсгээсээ Бямбацогт даргаа хэрэв зөвшөөрвөл энэ Төрийн албан тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3 дахь заалтыг эшлэснээ хасах нь зөрчилгүй болох юм. Зөвхөн Монгол Улсын шүүхийн тухай хуулиа үндэслэх нь л зөв болно. Тийм редакцияар та зөвшөөрвөл. Тийм Шүүхийн тухай хууль дээрээ шийдсэн учраас.

С.Бямбацогт: Ажлын хэсэг тэгвэл саяын Баасандорж даргын хэлж байгаа санал ажлын хэсгийнхэн бас ойлгож байгаа юм байна. 57.2.3 дахь заалтыг эшлэснээ аваад тэр шүүхийн тухай хуулиараа зохицуулна гээд өөрт нь орсон байгаа учраас энүүгээрээ явъя гэж байна. Чуулган руу оруулахдаа ийм байдлаар оруулах нь байна шүү. Ингээд дараагийн асуудалдаа оръё гэсэн шүү дээ. Энэ асуудал дууссан. Хэн сугалаад гараад явсан бэ энэ хүмүүсийг картыг. Дараагийн асуудал ирцгүй болчихлоо тийм ээ. Шүүхийн тухай хуулиа хэлэлцээд дууссан шүү бид нар. Саяын асуудлыг протоколд тэмдэглүүлээд үлдээсэн. Хамтдаа сая ярьсан шүү дээ тэрийг чинь. Тийм. Бусад хуулиуд руу оръё. Яах вэ цайны дараа хуралдах юм уу. Ирцгүй болно доо тийм ээ. Тогтоолоо ярьсан бид нар түрүүн би яасан шүү дээ ярьсан. Хамтад нь ярьсан шүү дээ тийм. Шүүхийн тухай хуулийг бүгдийг нь хэлэлцсэн. Би тийм үү хууль баталсантай холбогдуулах хэрэгжүүлэх арга хэмжээний тухай болон шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя гээд

хамтад нь хэлэлцээд тэгээд явсан шүү. Та горимын санал гаргаад хэлэлцэх эсэхийг анхны хэлэлцүүлгээр баталъя гээд явсан. Шүүхийн тухай хууль бол бүтэн дууссан. Харин дараагийн 3 дахь хууль, 4 дэх асуудал Барааны тэмдэгтийн хууль байсан. Харийн тийм. Ирцээ оруулаад хэн Энх-Амгалан гишүүнийг дуудъя. Алтанхуяг гишүүнээ одоо дараагийн асуудалдаа хэдүүлээ гялалзуулъя тэгэх үү. Хэлэлцэх эсэхийн хэдхэн асуудал байгаа. Харин ирц бүрдэхгүй байж магадгүй. Уг нь бол гайгүй асуудлууд байгаа. Яах вэ дээ одоо тэгээд. Харин үдээс хойш хуралдахгүй ингээд дуусгая. Тийм. Хүрнэ Энх-Амгалан гишүүн орвол хүрнэ. Дараагийн асуудалдаа оръё.